



БИЧИЛ САНХҮҮГИЙН САЛБАР ДАХЬ ФИНТЕК ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Б.Гал

ХУРААНГУЙ

Энэхүү судалгааны ажлаар банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-аас харилцагч нарт хүргэж буй технологид суурилсан зээлийн үйлчилгээ буюу финтек зээлийн үйлчилгээний зохицуулалтын орчныг сайжруулах талаар судалсан болно.

Судалгааны ажлаар финтек зээлийн зохицуулалтыг хэрэгжүүлж буй улс орнуудын туршлагыг харьцуулан судалж, ББСБ-аас түүвэр судалгаа авсны үндсэн дээр цаашид сайжруулах шаардлагатай зохицуулалтын саналыг боловсрууллаа.

Түлхүүр үгс: финтек зээл, финтек, дижитал зээл, цахим зээл, финтекийн хууль эрх зүй

JEL ангилал: G28

АГУУЛГА >>>

I.	УДИРТГАЛ	183
II.	ФИНТЕК ЗЭЭЛ.....	184
	Финтек зээл.....	184
	Финтек зээлийн хувьслын үе шат.....	184
	Финтек зээлийн төрлүүд	184
III.	ФИНТЕК ЗЭЭЛИЙН ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	187
	Зохицуулалтын орчин.....	188
	Хариуцлагатай финтек зээлийг дэмжих 10 зарчим	189
	Танзани улсын финтек зээлийн зохицуулалт	192
	Их британи улсын финтек зээлийн зохицуулалт	195
	Энэтхэг улсын финтек зээлийн зохицуулалт	197
IV	АҒИ-ИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ФИНТЕК ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ 10 ЗАРЧИМ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ.....	200
V.	МОНГОЛ УЛСЫН ФИНТЕК ЗЭЭЛ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ.....	203
	Финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага	203
VI.	МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ ЗЭЭЛИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА	207
	Судалгааны үр дүн.....	208
VII.	ДҮГНЭЛТ, САНАЛ	208
VIII.	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	210

ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Балансын зээл	185
Зураг 2.	Peer-to-peer зээл	186
Зураг 3.	Нэхэмжлэлийн арилжаа	186
Зураг 4.	Финтекийн үйл ажиллагаа төрлөөр	187
Зураг 5.	Цахим зээлийн хөгжлийн үйл явц	204
Зураг 6.	Финтек зээлийн бүтээгдэхүүн гаргасан ББСБ-уудын тоо	204
Зураг 7.	Финтек зээлийн экосистем	206
Хүснэгт 1.	Финтек зээлийн гол онцлог, давуу талууд	184
Хүснэгт 2.	Ашигт ажиллагаа	205

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

AFI	Alliance for Financial Inclusion	Санхүүгийн хүртээмжийн нийгэмлэг
AML	Anti-Money Laundering	Мөнгө угаахтай тэмцэх
API	Application Programming Interface	Программын интерфейс
APAC	Asia-Pacific	Ази-Номхон далайн бүс
BIS	Bank for International Settlements	Олон улсын төлбөр тооцооны банк
BNPL	Buy Now, Pay Later	Одоо аваад, дараа нь төл
BoE	Bank of England	Английн төв банк
BOT	Bank of Tanzania	Танзани Улсын төв банк
ББСБ	Non-Bank Financial Institution	Банк бус санхүүгийн байгууллага
CCAF	Cambridge Centre for Alternative Finance	Кембрижийн алтернатив санхүүгийн төв
DLAI	Digital Lenders Association of India	Энэтхэг Улсын финтек зээлдүүлэгчдийн Холбоо
DFS	Digital Financial Services	Дижитал санхүүгийн үйлчилгээ
FCA	Financial Conduct Authority	Их Британийн Санхүүгийн зохицуулагч байгууллага
FOS	Financial Ombudsman Service	Санхүүгийн омбудсманы үйлчилгээ
FSB	Financial Stability Board	Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөл
FSMA	Financial Services and Markets Act	Санхүүгийн үйлчилгээ ба зах зээлийн хууль
GDPR	General Data Protection Regulation	Ерөнхий мэдээллийн хамгаалалтын дүрэм
ICO	Information Commissioner's Office	Мэдээллийн комиссарын газар
KFS	Key Fact Statement	Стандарт баримт бичиг
KYC	Know Your Client	Үйлчлүүлэгчийг таних
MNOs	Mobile Network Operators	Гар утасны сүлжээний операторууд
NBFCs	Non-Banking Financial Companies	Банк бус санхүүгийн компаниуд
NCSC	National Cyber Security Centre	Үндэсний кибер аюулгүй байдлын төв
NPCI	National Payments Corporation of India	Үндэсний төлбөрийн корпорац
NSFE	National Strategy for Financial Education	Санхүүгийн боловсролын үндэсний стратеги
ODR	Online Dispute Resolution	Онлайн маргааны шийдэл
P2P	Peer to Peer	Хэрэглэгчээс хэрэглэгч рүү
PPIs	Prepaid Payment Instruments	Урьдчилж төлсөн төлбөрийн хэрэгсэл
ROA	Return on Assets	Нийт хөрөнгийн өгөөж
ROE	Return on Equity	Өөрийн хөрөнгийн өгөөж
RBI	Reserve Bank of India	Энэтхэгийн төв банк
SEBI	Securities and Exchange Board of India	Үнэт цаас болон хөрөнгө оруулалтын зохицуулах зөвлөл
SME	Small and Medium Enterprises	Жижиг, дунд аж ахуйн нэгжүүд
SSA	Sub-Saharan Africa	Сахарын өмнөд Африк
C3X	Financial Regulatory Commission	Санхүүгийн зохицуулах хороо
TCRA	Tanzania Communications Regulatory Authority	Танзани улсын харилцаа холбооны зохицуулалтын газар
UPI	Unified Payments Interface	Нэгдсэн төлбөрийн интерфейс

I. УДИРТГАЛ

Бичил санхүүгийн зээл нь бага, дунд орлоготой иргэдийн шаардлагатай хэрэгцээг хангах, хувиараа хөдөлмөр эрхлэгч болон бичил аж ахуйн нэгжүүдийн бизнесийг дэмжих санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх санхүүгийн чухал зах зээлийн нэг юм. “Финтек зээл”-ийн үйлчилгээ нь зээлийг цахим байдлаар хурдан шуурхай цаг алдалгүй авах боломжийг иргэд болон аж ахуй нэгжүүдэд олгосноор санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулж байна.

Финтек зээл нь 1990–ээд оны сүүл үеэс буюу интернэт олон нийтэд түгээмэл болж эхэлсэн цагаас үүссэн. Түүний төрлүүд нь зах зээлийн динамик шинж чанараас шалтгаалан өөр өөр байдаг ч үндсэн дөрвөн хэд хэдэн төрөл байдаг. Финтек зээл нь уламжлалт зээлийг илүү боловсронгуй болгосон.

Финтек зээлийн эрхзүйн орчин болон зохицуулалтыг олон улсын түвшинд ч, улс орнуудын түвшинд ч тодорхой хэмжээнд боловсруулаад байгаа бөгөөд цаашид шинэ тутам гарч буй финтек бүтээгдэхүүн болон одоогийн боловсруулсан зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

Монгол Улсад финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлж эхэлснээс хойш санхүүгийн хүртээмж илт нэмэгдсэн бөгөөд 2018–2023 онд 2.8 дахин өсөж давхардсан тоогоор 4,5 сая харилцагч үйлчлүүлж байна. Финтек зээлийн шинэ бүтээгдэхүүн турших финтек зээлийн зах зээлд

цаашид ч олон боломжууд байгаа бөгөөд өсөх хандлагатай байгааг судлаачид онцолж байна.

Монгол Улсын хувьд бичил зээлийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос олгодог ба сүүлийн жилүүдэд финтек зээлийн үйл ажиллагаа эрхлэх ББСБ–уудын тоо өсөж байгаа нь зохицуулалтын орчныг бүрдүүлэх түүний хяналт шалгалтыг сайжруулах хэрэгцээг үүсгэж байна. Иймээс олон улсын шилдэг зохицуулалтын туршлагыг мөн Монгол Улсын зохицуулалтын орчин хэрэглэгчид болон зээлийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдлыг судаллаа.

Судалгааны ажлаар финтекийн тухай, ББСБ–уудын өнөөгийн финтек зохицуулалтын талаарх түүвэр судалгааг хийн, финтек зээлийн үйлчилгээний зохицуулалтаар Улс орнуудын сайн туршлагыг судалж, Монгол Улсад хэрэгжүүлэх саналыг дэвшүүллээ.

Энэхүү судалгааны ажил нийт 7 бүлэгтэй. Дараагийн бүлэгт финтек зээл түүний төрлүүдийн талаар танилцуулна. Судалгааны гурав, дөрөв болон тав дугаар бүлэгт харгалзан Олон улсын болон Монгол Улсын финтек зээлийн өнөөгийн байдал, түүний зохицуулалт мөн AFI–ийн хариуцлагатай зээлийн 10 зарчмын харьцуулсан шинжилгээг хийлээ. Харин зургаадугаар бүлэгт Монгол Улсын финтек зээлийн түүвэр судалгааны талаар, эцсийн долоодугаар бүлэгт дүгнэлт болон саналыг оруулав.

II. ФИНТЕК ЗЭЭЛ

Финтек зээл гэдэг нь онлайн технологи, дата аналитик ашиглан дижитал платформоор дамжуулан санхүүгийн зээл, зээлийн үйлчилгээ үзүүлэх үйл явцыг хэлнэ. Энэ нь зээлийн хүсэлт, шийдвэр, зарцуулалт, эргэн төлөлтийн үйл явцыг хөнгөвчлөхийн тулд цахим хуудас, гар утасны аппликэйшн, онлайн портал зэрэг дижитал сувгуудыг ашиглах явдал юм. Технологийн хурдацтай дэвшил, онлайн болон мобайл банкны үйлчилгээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор финтек зээл сүүлийн жилүүдэд түгээмэл болж байна.

Энэхүү орчин үеийн арга барилаар зээлдэгчид онлайн платформоор дамжуулан зээл авах

хүсэлт гаргадаг. Зээлдүүлэгчид харилцагчийн зээлийн чадварыг үнэлэхийн тулд дэвшилтэт технологи, мэдээллийн аналитик ашиглаж үнэлдэг. Дараа нь зээлийн мэдээллүүдийг цахим хэлбэрээр эцэслэн боловсруулж, санхүүжилтийг дижитал хэлбэрээр олгодог. Зээлдэгч нь зээлийн эргэн төлөлтийг онлайнар хийдэг бөгөөд энэ нь зээлийн бүх үйл явцыг уламжлалт аргуудаас илүү үр ашигтай, оновчтой, хялбар болгож зээл олгох үйл явцад хувьсал хийсэн юм. Нэмж дурдахад финтек зээл нь нэгэн зэрэг хувь хүн, аж ахуйн нэгжүүдийн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, тав тухтай байдлыг бий болгож, санхүүгийн салбарт инновацыг дэлгэрүүлсэн.

Хүснэгт 1. Финтек зээлийн гол онцлог, давуу талууд

Тав тухтай байдал	Финтек зээл нь зээлдэгчдэд илүү тохиромжтой, хялбаршуулсан зээлийн процессыг санал болгож, зээлдэгчид хаа байгаа газраасаа гар утсаараа дамжуулан зээл авах боломжийг олгодог.
Хурдан шуурхай	Дижитал платформыг ашиглах нь зээлийг илүү хурдан олгох, зээлийн төлбөрийн чадварыг үнэлэх ба санхүүжилт олгоход зарцуулдаг цаг хугацааг багасгадаг.
Хүртээмжтэй байдал	Финтек зээлийн платформууд нь уламжлалт банкны үйлчилгээг авах боломж хязгаарлагдмал алслагдсан бүс нутгийн иргэдийг оролцуулан илүү өргөн хүрээний хэрэглэгчдэд хүрч чаддаг.
Мэдээлэлд тулгуурласан шийдвэр гаргах	Финтек зээл нь зээлийн эрсдэлийг үнэлэх, зээлийн шалгуурыг тодорхойлох, хувийн оноог тогтоох зорилгоор мэдээллийн аналитик, хиймэл оюун ухаан, машин сургалтын алгоритмуудыг ашигладаг.
Хэрэглэгчийн туршлагыг сайжруулсан	Зээлдэгч нь бодит цаг үеийн мэдээлэлд хандах, зээлийн статусаа хянах боломжтой байдаг.
Үйл ажиллагааны зардал бага	Финтек зээл олголт нь биет дэд бүтэц, бичиг баримтын хэрэгцээг багасгаж, улмаар зээлдүүлэгчдийн зардлыг хэмнэдэг.

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Финтек зээлийн хувьслын үе шат

Финтек зээлийн түүх нь интернэтийн эхэн үе, онлайн санхүүгийн үйлчилгээ бий болсон үеэс

эхэлдэг. Финтек зээлийн хувьслын үе шатууд:

1990–ээд оны сүүл үе: Интернэт түгээмэл болж, санхүүгийн байгууллагууд онлайн банкны

үйлчилгээг судалж эхлэв. Гэсэн хэдий ч зээл олгох үйл явц нь цаасан дээр суурилсан хэвээр байсан бөгөөд зээлдэгчид биет салбарууд дээр очих шаардлагатай байв.

2000–аад оны эхэн үе: Peer-to-peer (P2P) зээлийн платформууд үүсэж, тэлж эхэлсэн нь зээлийн үйл ажиллагаанд мэдэгдэхүйц өөрчлөлт гарсан. Анхны алдартай P2P зээлийн платформ болох Zora нь 2005 онд Их Британид байгуулагдсан. Энэ нь хувь хүмүүст онлайн платформуор дамжуулан бие биеэсээ шууд мөнгө зээлэх, зээлүүлэх боломжийг олгосон.

2000–аад оны дунд үе: Онлайн зээлийн платформууд бий болж, хувийн зээл болон бусад төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг онлайнар санал болгож эхэлсэн. Эдгээр платформууд нь зээлийн хүсэлтийн процессыг хялбарчилж, зээлийн үнэлгээ болон зээлийн шийдвэрийг оновчтой болгохын тулд технологийг ашигласан.

2000–аад оны сүүл үе: Ухаалаг гар утас интернэтийн хэрэглээ тархсанаар гар утасны зээлийн аппликейшнууд түгээмэл болж эхэлсэн. Зээлдэгч мобайл төхөөрөмжөөсөө зээл авах хүсэлт гаргаж, дансаа удирдах боломжтой болсон.

2010 он: Финтек зээлийн салбар хурдацтай хөгжиж эхэлсэн. Шинэ тоглогчид зах зээлд нэвтэрч, одоо байгаа платформууд нь бизнесийн зээл, оюутны зээл гэх мэт бүтээгдэхүүнээ өргөжүүлсэн. Өгөгдлийн аналитик болон зээлийн онооны өөр загваруудыг ашигласнаар онлайн зээл илүү боловсронгуй болсон.


2015 он: «Финтек» нэр томьёо нь технологид тулгуурласан санхүүгийн үйлчилгээний өсөн хөгжиж буй салбар, тэр дундаа финтек зээлийг тодорхойлоход өргөн хэрэглэгдэх болсон.

2020–иод он: Технологи хөгжихийн хэрээр финтек зээл илүү хувийн шинж чанартай, хүртээмжтэй болсон. Зээлийн эрсдэлийг үнэлэх, шийдвэр гаргахад хиймэл оюун ухаан, машин сургалт улам бүр чухал үүрэг гүйцэтгэж эхэлсэн.

Финтек зээлийн төрлүүд

Балансын зээл (Balance sheet lending): Балансын зээл гэдэг нь банк шиг санхүүгийн байгууллага өөрийн хөрөнгөөр зээлээ санхүүжүүлдэг зээлийн уламжлалт хэлбэр юм. Финтек зээлийн хувьд энэ үйл явцыг автоматжуулж, онлайн платформуор дамжуулан хөнгөвчлөх замаар зээлдэгчдэд шууд зээл олгодог.

Зураг 1. Балансын зээл




Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Peer-to-peer зээл: Peer-to-peer (P2P) зээл нь бие даасан зээлдэгчийг хувийн хөрөнгө оруулагчид эсвэл зээлдүүлэгчидтэй онлайн платформоор

дамжуулан холбодог. Энэ нь хүмүүс бие биедээ шууд мөнгө зээлэх, зээлдүүлэх боломжийг олгодог.

Зураг 2. Peer-to-peer зээл




Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Нэхэмжлэлийн арилжаа (Invoice Trading): Бизнес эрхлэгчид үлдэгдэл нэхэмжлэхээ хөрөнгө оруулагч эсвэл зээлдүүлэгчид хямдралтай үнээр зарах боломжийг олгодог.

Энэ нь бизнес эрхлэгчдэд төлөгдөөгүй нэхэмжлэхээ платформоор дамжуулан бэлэн мөнгө болгон авах боломжийг олгодог.

Зураг 3. Нэхэмжлэлийн арилжаа



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Бусад финтек зээлийн шийдлүүд (Other Digital Credit Solutions):

- Хэрэглэгчийн худалдан авалтын санхүүжилт, бэлэн мөнгөний урьдчилгаа (Consumer purchase financing costumer cash-advance): Бэлэн мөнгөний урьдчилгаа нь хувь хүмүүст ирээдүйн орлого эсвэл цалингийнхаа төлбөрийг ихэвчлэн өндөр хүүтэй зээлэх замаар бэлэн мөнгө авах боломжийг олгодог. Хэрэглэгчийн худалдан авалтын санхүүжилт нь хэрэглэгч худалдан авалт хийж,

төлбөрөө хэсэгчлэн төлөх боломжийг олгодог. Buy Now Pay Later үйлчилгээ нэг хэсэг нь юм.


- Худалдаачдын бэлэн мөнгөний урьдчилгаа (Digital merchant-cash advance solutions): Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үзүүлдэг санхүүгийн үйлчилгээний нэг төрөл юм. Бизнес эрхлэгчдэд ирээдүйн орлого, зээлийн борлуулалтын тодорхой хэсгийг санхүү үйлчилгээ эрхлэгчдэд зарах замаар шууд бэлэн мөнгө авах хурдан тохиромжтой арга юм.

III. ФИНТЕК ЗЭЭЛИЙН ОЛОН УЛСЫН ЗОХИЦУУЛАЛТ, ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Дэлхийн финтек зээлийн зах зээлийн хэмжээ 2023 онд 13.1 тэрбум ам.долларт хүрчээ¹, 2033 он гэхэд CAGR буюу дэлхийн зах зээлийн дундаж өсөлт 23.4 хувиар өсөж 107 тэрбум ам.долларт хүрэх төлөвтэй байна.

Дэлхийн финтек зээлийн зах зээл нь тогтвортой өсөлтийг үргэлжлүүлэн харуулж мөн финтекийн экосистемд чухал үүрэг гүйцэтгэсээр байна. Кембрижийн алтернатив санхүүгийн төв (CCAF) болон дэлхийн эдийн засгийн форумын 2024 оны тайланд дурдсанаар финтек зээл нь дэлхийн финтекийн салбарын чухал хэсэг болж нийт финтекийн үйл ажиллагааны ойролцоогоор 27%-ийг бүрдүүлж байна. Энэхүү салбар нь ялангуяа уламжлалт банкны үйлчилгээ хязгаарлагдмал хөгжиж буй зах зээлүүдэд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.

Зураг 4. Финтекийн үйл ажиллагаа төрлөөр



Эх сурвалж: Кембрижийн алтернатив санхүүгийн төв

Финтекийн зах зээл нь Ковид-19 цар тахлын дараа финтекийн зах зээлийн үйлчлүүлэгчдийн тоо өссөөр байгаа нь тахлын өмнөх болон тахлын үеэр ажиглагдсан өсөлтийн эрч хүчийг хадгалсаар байна. Дижитал санхүүгийн үйлчилгээний хүртээмж сайжирч, хэрэглэгчдийн сонирхол, финтек үйлчилгээний

¹ <https://www.researchandmarkets.com/>

эрэлт нэмэгдсэн. Финтек зээлийн хэрэглэгчид мөн өсөлтөө хадгалсаар байгаа бөгөөд 2020–2022 оны хооронд харилцагчид жилд дунджаар 50%–иас дээш харилцагчийн өсөлт үзүүлсэн байна. Энэхүү өсөлт нь ялангуяа SSA болон APAC зэрэг бүс нутагт уламжлалт санхүүгийн байгууллагуудын үлдээсэн орон зайг нөхөж байгаагаараа онцлог юм.

Дэлхийн финтек зээлийн зах зээл өсөлттэй байгаа боловч бүс нутгийн сорилтуудтай тулгарч байна. Жишээлбэл: SSA–д өсөлт нь агентын сүлжээ болон дижитал дэд бүтцийн дутагдал зэрэг дэд бүтцийн хязгаарлалтаас болж саарсан байна. Эдгээр сорилтуудын хажуугаар бүс нутагт гар утасны цахим мөнгөний платформоос үүдэлтэй финтек зээлийн өсөлт өндөр хэвээр байна. Харин Европ, Хойд Америк зэрэг илүү хөгжингүй зах зээлүүд нь зохицуулалтын бэрхшээлүүдтэй тулгарч, олон финтек зээлийн цаашдын өсөлтийг саатуулж байгаа гол саад бэрхшээл болж байна.

Ирээдүйд финтек зээлийн зах зээл технологийн дэвшлүүд, ялангуяа хиймэл оюун ухаан болон их өгөгдлийн аналитик зэрэг технологиудын нөлөөгөөр хүчтэй өсөлтийг үргэлжлүүлнэ гэж хүлээгдэж байна. Эдгээр технологиуд нь зээлийн онооны загвар болон эрсдэлийн үнэлгээг сайжруулж байна. Гэсэн хэдий ч салбар нь үргэлжлэн өсөлтөө хадгалахын тулд зохицуулалтын үргэлжилсэн сорилтууд болон эдийн засгийн тодорхой бус байдалд анхаарлаа хандуулах шаардлагатай болно. Мөн дээрх тайланд инновацыг дэмжихийн зэрэгцээ хэрэглэгчийг хамгаалах тэнцвэрийг хангах тодорхой зохицуулалтын хүрээг бий болгохыг онцолсон. Энэ нь ялангуяа хөгжиж буй зах зээлд маш чухал бөгөөд үр дүнтэй финтек зээлийн зохицуулалт нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой.

Зохицуулалтын орчин

Финтек зээлийн талаар олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн санхүүгийн зохицуулалтын стандарт, бодлого байхгүй бөгөөд улс орон бүр өөрийн санхүүгийн зах зээл дэх эрсдэлийг удирдах, үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлдэг. Олон улсын төлбөр тооцооны банк (BIS) болон Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлийн (FSB) тайланд дурдсанаар, зохицуулалтын хандлагыг ерөнхийд нь гурван чиглэлд хувааж үздэг:

1. Одоо байгаа хүрээг өөрчлөн зохицуулах

Олон улс оронд финтек зээлийг зохицуулахдаа одоо байгаа санхүүгийн зохицуулалтын хүрээг шинэ нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх замыг сонгосон байдаг. Энэ нь уламжлалт санхүүгийн байгууллагуудад мөрдөгддөг зохицуулалтыг финтек компаниудад хэрэгжүүлэхийг шаарддаг. Жишээлбэл: олон улс оронд финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд банкны лиценз авах, мөнгө угаахтай тэмцэх (AML) болон үйлчлүүлэгчийг таних (KYC) журамд нийцэх ёстой байдаг. Энэ хандлага нь финтек зээл олгогчдыг тогтсон санхүүгийн байгууллагуудтай адил хэрэглэгчийг хамгаалах болон санхүүгийн тогтвортой байдлын шаардлагад нийцүүлэн хяналт тавих боломжийг бүрдүүлдэг.

2. Финтект зориулсан шинэ зохицуулалт нэвтрүүлэх

Зарим улсад финтек зээлийн өвөрмөц онцлогийг хүлээн зөвшөөрч, холбогдох эрсдэл болон боломжийг шийдвэрлэх зорилгоор тусгай зохицуулалтыг боловсруулсан байдаг. Жишээ нь, Их Британийн санхүүгийн үйлчилгээний хороо (FCA) нь P2P платформуудыг зохицуулах зориулалттай системийг анхлан нэвтрүүлсэн. Эдгээр зохицуулалтууд нь ил тод байдал, эрсдэлийн удирдлага, хэрэглэгчийг

хамгаалахад анхаардаг бөгөөд салбар дахь инновацыг дэмждэг. Үүнтэй төстэй байдлаар Хятад Улс P2P зээлийн платформуудад хатуу зохицуулалт нэвтрүүлсэн бөгөөд энэ нь луйвар болон санхүүгийн тогтворгүй байдалд хариу үйлдэл үзүүлэх зорилготой юм.

3. Финтек зээлийг дэмжихэд зориулсан бодлого

Зарим Засгийн газрууд финтек зээлийн өсөлтийг дэмжихийн зэрэгцээ түүний эрсдэлийг үр дүнтэй удирдахын тулд бодлогын тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлдэг. Тухайлбал Их Британи улсад финтекийн платформд хөрөнгө оруулж буй хөрөнгө оруулагчдад татварын хөнгөлөлт үзүүлэх мөн Их Британийн бизнесийн банк нь Funding Circle-тэй хамтран жижиг бизнесүүдэд зээл олгох Засгийн газрын дэмжлэгтэй санаачилгуудыг хэрэгжүүлж байна. Эдгээр бодлогын арга хэмжээнүүд нь салбар дахь хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, санхүүгийн үйлчилгээ хүртэхэд бэрхшээлтэй бүлэг болон жижиг бизнесүүдэд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн байдаг.

Зохицуулалтын гол сорилтууд

Хэрэглэгчийн хамгаалалт: Дэлхий даяар хэрэглэгчийг хамгаалах асуудал нэн тэргүүнд тавигдаж байна. Зохицуулагчид зээлийн нөхцөл, болзлын ил тод байдлыг сайжруулах, хууль бус өндөр хүүтэй зээлээс сэргийлэх, мөн хэрэглэгчдийг финтек зээлийн эрсдэлүүдийн талаар бүрэн ойлголттой болгох чиглэлд онцгойлон анхаарч байна.

Санхүүгийн тогтвортой байдал: Финтекийн зээл нийт зээлийн зах зээлийн томоохон хэсгийг эзлэх эрсдэлтэй учраас санхүүгийн тогтвортой байдалд зохицуулагчид анхааран ажиллаж байна. Зохицуулагчид финтекийн зээлийн эдийн засгийн мөчлөгөөс хамаарах хандлага буюу эдийн засгийн өсөлт, бууралттай уялдан зээлийн хүртээмж ихсэж, багасах хандлагад

онцгой анхаарал хандуулж байгаа юм. Хөрөнгө оруулагчдын итгэл гэнэт алдагдах үед санхүүжилт хурдан татагдан, зээлийн хүртээмж огцом буурч, зах зээлийн тогтворгүй байдлыг улам хурцатгах аюултай байна.

Мэдээллийн нууцлал ба кибер аюулгүй байдал: Дижитал платформуудын хурдацтай хөгжил нь мэдээллийн нууцлал болон кибер аюулгүй байдлыг нэн тэргүүнд тавихыг шаарддаг. Зохицуулагчид финтекийн платформуудыг хэрэглэгчдийн мэдээллийг найдвартай хамгаалж, кибер халдлагаас сэргийлэх системтэй байхыг баталгаажуулах шаардлагатай байна.

Улс орнууд финтекийн зээлийн өгөөж болон эрсдэлийг удирдахад чиглэсэн өөр өөр аргуудыг нэвтрүүлсэн бөгөөд зарим нь одоо байгаа зохицуулалтуудаа өөрчлөн тохируулж, зарим нь энэ салбарт зориулсан шинэ зохицуулалтын хүрээ бий болгож байна. Зохицуулагчдын хувьд инновацыг дэмжихийн зэрэгцээ санхүүгийн тогтвортой байдал болон хэрэглэгчийг хамгаалах тэнцвэрийг хадгалах нь чухал сорилт хэвээр байна.

Хариуцлагатай финтек зээлийг дэмжих 10 зарчим

AFI-аас гаргасан Хариуцлагатай финтек зээлийн бодлогын хүрээ нь гишүүн орнууд финтек зээлийг зохицуулах, хянах AFI-ийн гишүүн орнуудын чадавхыг бэхжүүлэх, шилдэг туршлагыг хуваалцах хэрэгсэл болох зорилготой. Бодлогын хүрээ нь хариуцлагатай финтек зээлийн дэглэмийг хөгжүүлэхэд тавигдах хамгийн бага зохицуулалт, хяналтын шаардлагыг хангадаг. Зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд хялбар болгох үүднээс эдгээр наад захын шаардлагыг 10 үндсэн зарчимд нэгтгэсэн болно. AFI-ийн гишүүд бодлого, зохицуулалтын орчноо сайжруулах, хариуцлагатай финтек зээлийн бүтээгдэхүүн,

үйлчилгээг дэмжихийн тулд эдгээр зарчмуудыг ашиглахыг зөвлөдөг байна.

Энэхүү бодлогын хүрээнд финтек зээлийг дижитал хэрэгслээр дамжуулан бичил зээлийг олгох гэж тодорхойлсон. Гол шинж чанарууд нь бага дүнтэй зээл, богино хугацаатай, дижитал сувгаар санал болгох, алсаас хандах, хурдан шуурхай зэрэг орно.

Зарчим 1. Эрх зүйн бүртгэл, зохицуулалтын

хүрээ: Эрх баригчид лиценз, зохицуулалт, хяналтыг багтаасан финтек зээлийг хянах хууль эрх зүйн тодорхой бүрэн эрх мэдэлтэй байх ёстой. Гол нь зохицуулалтын иж бүрэн эрх олгох, зарчимд суурилсан, пропорциональ хандлагыг ашиглах, дагаж мөрдөх журмыг хэрэгжүүлэх, зохицуулалттай байгууллагуудын хамтын ажиллагааг дэмжих зэрэг багтана. Энэхүү бүрэн эрх нь зах зээлийн шударга байдал, үр дүнтэй хяналтыг баталгаажуулж, олон төрлийн үйлчилгээ үзүүлэгчдийн дунд хариуцлагатай финтек зээлийг дэмжинэ.

Зарчим 2. Байгууллагын чадавх:

Зохицуулагч байгууллагууд нь цахим зээлийн зах зээлийг үр дүнтэй хянахад шаардлагатай техникийн ур чадвар, нөөц, хяналтын хэрэгслүүдтэй байх ёстой. Үүнд зах зээлийн хяналтын үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх тусгай нэгжүүдийг байгуулах, эрсдэлд суурилсан хяналтын аргыг ашиглах зэрэг орно.

Зарчим 3. Зээлийн цогц, үр дүнтэй мэдээллийн

систем: Эрх баригчид бүх санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, тэр дундаа банк бус финтек зээлдүүлэгчдийн мэдээллийг багтаасан найдвартай зээлийн мэдээллийн системийг бий болгох ёстой. Гол талууд нь зээлийн мэдээллийн системийн үүрэг, чадавхыг өргөжүүлэх, хэрэглэгчийн санхүүгийн мэдээллийн хүртээмжтэй байдлыг тодорхойлох, өөр өгөгдлүүд ашиглах, шударга шалгуурыг хангах, хэт өндөр өрийн эрсдэлийг бууруулах

зохицуулалтыг бий болгох явдал юм.

Зарчим 4. Ил тод байдал: Эрх баригчид цахим зээлийн үйлчилгээ үзүүлэгчдийн ил тод байдал болон мэдээллийн ил тод байдлыг хатуу мөрдүүлэх шаардлагатай. Үүнд зээлийн нөхцөл, хүү, шимтгэл болон төлбөр саатвал гарах үр дагаврын талаар тодорхой мэдээлэл өгөх орно. Ил тод байдал нь хэрэглэгчдийг зөв шийдвэр гаргахад тусалж, цахим зээлийн үйлчилгээнд итгэл төрүүлдэг.

Зарчим 5. Салбарын ёс зүйн дүрэм:

Эрх баригчид бүх санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч, тэр дундаа ББСБ-уудад үйлчлүүлэгчидтэй шударга харьцах, ил тод байдал, өр төлбөрийг ёс зүйн дагуу нөхөн төлүүлэх, гомдлыг үр дүнтэй шийдвэрлэх зэрэг салбарын ёс зүйн дүрмийг дагаж мөрдөхийг үүрэг болгох ёстой. Энэхүү дүрэм нь финтек зээлийн бүтээгдэхүүний загвар, нийлүүлэлтийн явцад хариуцлагатай үйл ажиллагааг хангадаг. Ийнхүү дүрмийг хэрэгжүүлснээр зах зээлийн өөрийн зохицуулалтыг сайжруулах, хэрэглэгчдийн итгэлийг нэмэгдүүлэх, чанартай үйлчилгээ үзүүлэх, санхүүгийн хүртээмжтэй байдал, зорилтот хувь хүн, жижиг бизнесийг өргөжүүлэхийг дэмжих болно.

Зарчим 6. Мэдээллийн хамгаалалт, нууцлал:

Хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах нь финтек зээл болон бусад санхүүгийн үйлчилгээ хэрэглэгчдэд өөрсдийн өгөгдөл нь хувийнх бөгөөд зохих ёсоор ашиглагдаж байгаа гэдэгт итгэх итгэлийг өгөхөд чухал үүрэгтэй. Үйлчилгээ үзүүлэгч нь хууль тогтоомжийг дагаж мөрдөхөөс бусад тохиолдолд хэрэглэгчийн мэдээллийг тэдний зөвшөөрөлгүйгээр хуваалцахыг хязгаарлах нь санхүүгийн үйлчилгээ авахдаа хэрэглэгчдэд шударга бус хандах, ялгаварлан гадуурхах, залилуулахгүй байх зэрэг зах зээлийн шударга байдлыг нэмэгдүүлдэг. Нийтлэг зарчимд нийцсэн, бүс нутаг хоорондын

мэдээллийн урсгалыг дэмжсэн, тогтсон арга барилтай бүс нутгийн хамтран ажиллах боломжийг дэмжих нь хил дамнасан итгэлцэл, зохицуулалтын үр нөлөөг нэмэгдүүлдэг. Энэ нь хэрэглэгчийн хувийн нууцыг хамгаалж, финтек зээл зэрэг санхүүгийн үйлчилгээний зах зээлийн шударга байдлыг дэмждэг.

Зарчим 7. Луйвар, кибер аюулгүй байдал, тогтвортой байдал: Санхүүгийн дижитал үйлчилгээний гол цөм нь цахим аюулгүй байдлын асуудал юм. Хэрэглэгчийн мэдээллийн сан, тэдгээрийн мэдээлэл алдагдах нь хэрэглэгчдийн итгэл, санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон салбарын нэр хүндэд сөргөөр нөлөөлдөг. Залилангаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь үйлчилгээ үзүүлэгчдийг уян хатан байлгахад чухал үүрэгтэй. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн шинж чанараас шалтгаалан эрх баригчид дотоодын оролцогч талуудтай (төрийн болон хувийн хэвшлийн хамтын ажиллагаа), мөн кибер аюулгүй байдлын талаар хил дамнасан хамтын ажиллагааг дэмжих нь зайлшгүй чухал юм. Залилангийн гэмт хэргийн тайланг холбогдох байгууллагад ирүүлэх нь залилангийн гэмт хэрэг дахин гарахаас урьдчилан сэргийлэх, хамгаалахад тусална.

Зарчим 8. Дижитал санхүүгийн боловсрол: Дижитал санхүүгийн үйлчилгээний талаарх мэдлэг, ойлголт нь хэрэглэгчдэд тэдгээрт хандах, ашиглах талаар мэдээлэлтэй шийдвэр гаргах боломжийг олгодог. Ихэнх хэрэглэгчид санхүүгийн үйлчилгээний талаар нарийн ойлголттой байдаггүй, ялангуяа дижитал инновацаар дамжуулан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх динамик өөрчлөлтийг харгалзан үздэг. Санхүүгийн мэдлэг, боловсрол нь үндэсний болон салбарын

хамтын ажиллагааг шаарддаг нарийн төвөгтэй зүйл юм. Санхүүгийн боловсролын үндэсний стратеги нь салбарын хэмжээнд санхүүгийн боловсролыг хэрэгжүүлэх, хэрэглэгчдийн чадавхыг дээшлүүлэх үр дүнтэй, системтэй арга замыг бий болгодог. Мэдлэгийг дээшлүүлэх кампанит ажил нь залуучууд болон жендерт чиглэсэн дижитал санхүүгийн талаар санаачилгуудыг багтаасан байх шаардлагатай. Мөн эдгээр хөтөлбөрүүд нь цахим зээлийн үндсэн ойлголтуудыг, түүний дотор эрсдэлийн менежмент, санал гомдол, гомдол шийдвэрлэх үйл явцыг хамарсан байх ёстой.

Зарчим 9. Өрсөлдөөн, хамтын ажиллагаа: Эрх баригчид финтек зээл, санхүүгийн үйлчилгээнд шударга өрсөлдөөний дүрмийг мөрдүүлж, өрсөлдөөний эсрэг үйл ажиллагааг хориглох ёстой. Зохицуулагч байгууллагуудтай хамтран ажиллах нь сайн туршлагыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай. Санхүүгийн үйлчилгээ, дижитал үйлчилгээ хоорондын харилцан үйлчлэлийг дэмжих бодлого нь үр ашгийг дээшлүүлдэг. Шударга зах зээлийн өрсөлдөөн нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалж, сонголтыг өргөжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлдэг бол хамтын ажиллагаа нь үйлчилгээний үр ашгийг дээшлүүлдэг.

Зарчим 10. Гомдол, шийдвэрлэх систем: Хэрэглэгчийн эрхийг хамгаалахад хүртээмжтэй, үр дүнтэй санал гомдол ба гомдол шийдвэрлэх механизм шаардлагатай. Зохицуулагчид цахим зээлийн үйлчилгээ үзүүлэгчид шударга, түргэн шуурхай гомдол шийдвэрлэх системийг бий болгохыг баталгаажуулах ёстой. Эдгээр механизмын үр дүнтэй байдлыг хянахын тулд хэрэглэгчийн гомдлын талаар тогтмол мэдээлэхийг шаардах ёстой.

ТАНЗАНИ УЛСЫН ФИНТЕК ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Танзани Улс Африк тивд дижитал санхүүгийн үйлчилгээ (DFS)–ний тэргүүлэгч болж, финтек зээлийн салбарт санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн. Танзани Улсын туршлага нь хариуцлагатай финтек зээлийн дадал болон тэдгээрийг дэмжих зохицуулалтын арга барилыг хөгжүүлэхэд үнэтэй сургамж болж байна. Энэ хэсэгт Танзани улсын финтек зээлийн зах зээлийн өсөлт, тогтвортой байдлыг хангахад нөлөөлсөн зохицуулалтын тогтолцоо, үндсэн зарчмуудыг судалсан болно.

Танзани Улсын дижитал санхүүгийн үйлчилгээний хөгжил

Танзани Улсын дижитал санхүүгийн үйлчилгээний экосистем нь 2008 онд цахим мөнгөний үйлчилгээг нэвтрүүлснээс хойш ихээхэн хөгжиж эхэлсэн. Энэ салбар нь банкууд, гар утасны сүлжээний операторууд (MNOs), болон FinTech компаниудын хоорондын хамтын ажиллагааны үр дүн юм. Энэхүү финтек зээлийн хөгжилд гарсан гол үйл явдлууд нь гар утасны мөнгөний шийдлүүд, гар утасны хадгаламж, зээлийн үйлчилгээ, гар утасны түрийвчүүдийн хоорондын шилжүүлэг зэрэг юм.

Танзани Улсын финтек зээлийн салбарт Vodacom Tanzania, Commercial Bank of Africa, Airtel, Tigo зэрэг томоохон компаниуд давамгайлдаг. Эдгээр үйлчилгээ үзүүлэгчид зээлийн бүтээгдэхүүнээ цахим мөнгө хэлбэрээр хэрэглэгчдийн гар утасны түрийвчинд шууд олгодог. Жишээлбэл, Vodacom Tanzania компани нь Commercial Bank of Africa–тай хамтран M–Pawa хэмээх дижитал хадгаламж, зээлийн үйлчилгээг нэвтрүүлсэн нь ихээхэн амжилт олсон.

Финтек зээлийн зохицуулалтын тогтолцоо

Танзани Улсын Төв банк (BOT) нь финтек зээлийн зохицуулалтыг дэмжих зохистой орчныг бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Тус Улсын зохицуулалтын хандлага нь зах зээлд инновацыг дэмжих, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс «Суралцан турших» аргачлалыг нэвтрүүлсэн. Цаг хугацааны явцад BOT нь «Зааварчилж хяналт тавих» хандлага руу шилжсэн. Банк болон банкнаас бусад санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийг хянахдаа BOT нь Харилцаа Холбооны Зохицуулалтын Газартай (TCRA) нягт хамтран ажилладаг байна.

Танзани Улсад финтек зээлийг зохицуулдаг гол журам, удирдамжууд:

Танзани Улсын төв банкны тухай хууль (2006): Танзани улсын төв банкны үйл ажиллагааг хууль ёсны хүрээнд тогтоож өгөх суурь хууль юм. BOT–д тус улсын санхүүгийн систем, түүний дотор банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагуудаар дамжуулан хийгддэг төлбөрийн системүүдийг хяналтдаа авах эрх мэдэл олгодог. BOT нь төлбөрийн системүүдийн үйл ажиллагааг зохицуулах зорилгоор журам, заавар, удирдамж гаргах өргөн эрх мэдэлтэй. Энэ нь санхүүгийн тогтвортой байдал, хүртээмжийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Цахим мөнгөний зохицуулалт (2015): Энэхүү зохицуулалт нь Танзани дахь банкнаас бусад байгууллагуудаар дамжуулан цахим мөнгө (e–money) гаргах, удирдах бүрэн зохицуулалтын хүрээг бүрдүүлэхээр гарсан.

- Цахим мөнгө гаргах хүсэлтэй банкнаас бусад байгууллагууд, тухайлбал гар утасны операторын үйлчилгээ үзүүлэгч компаниуд BOT–оос лиценз

авах шаардлагатай. Энэ нь зөвхөн чадварлаг, тогтвортой байгууллагууд электрон мөнгөний үйл ажиллагаа эрхлэх боломжийг олгодог.

- Цахим мөнгө гаргагч байгууллагууд нь өөрийн бусад бизнесийн үйл ажиллагаанаас тусдаа хуулийн этгээдээр ажиллах ёстой. Энэ нь электрон мөнгөний үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг тусгаарлаж, хэрэглэгчдийг хамгаалахад тустай.
- Мөн цахим мөнгө гаргагч байгууллагууд нь гаргасан электрон мөнгөний үнэ цэнийг хадгалах зорилгоор лицензтэй банкнуудад итгэлцлийн данс нээх ёстой. Энэ нь цахим мөнгө гаргагч санхүүгийн хүндрэлтэй тулгарсан ч хэрэглэгчдийн мөнгийг хамгаалах баталгаа болдог.
- Хэрэглэгчийн эрхийг хамгаалахтай холбоотойгоор цахим мөнгөний үйлчилгээтэй холбоотой хураамж, төлбөрийг тодорхой, ил тод мэдээлэхийг шаарддаг. Энэ нь хэрэглэгчид гүйлгээ хийхээсээ өмнө бүрэн мэдээлэлтэй байх боломжийг бүрдүүлдэг.

Агент банкны удирдамж (2017): Энэхүү удирдамж нь ялангуяа хөдөө орон нутаг болон үйлчилгээ хүрэхгүй байгаа газруудад банк, санхүүгийн байгууллагуудын үйлчилгээг агентуудаар дамжуулан хүргэхийг зохицуулах зорилготой. Банкнууд болон санхүүгийн байгууллагууд гуравдагч этгээд болох агентуудыг агентуудыг (Жишээлбэл: жижиглэнгийн дэлгүүр, шуудангийн газар, хувь хүмүүс) өөрсдийн нэрийн өмнөөс үндсэн банкны үйлчилгээг санал болгохоор ажиллуулахыг зөвшөөрдөг. Эдгээр үйлчилгээнд бэлэн мөнгөний хадгаламж, зарлага, шилжүүлэг болон төлбөрийн үйлчилгээнүүд орно. Банкнууд болон санхүүгийн байгууллагууд агент банкны үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн

тулд ВOT-оос зөвшөөрөл авах ёстой. Агентууд хэрэглэгчдийн өгөгдлийг аюулгүйгээр хадгалах ёстой ба нууцлалыг сахин мөрдөх ёстой. ВOT нь агентуудын үйл ажиллагааг шалгах, хянах эрхтэй бөгөөд зохицуулалтын стандартыг хангаж буй эсэх, санхүүгийн системийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах үүднээс хяналт тавьдаг.

Бичил санхүүгийн тухай хууль (2018): Тус улсад үйл ажиллагаа явуулж буй бичил санхүүгийн байгууллагуудад (MFI), түүний дотор финтек зээлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад зориулсан зохицуулалтын хүрээг бий болгож өгсөн. Энэ нь ил тод байдлыг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг хамгаалах, бичил санхүүгийн салбарын тогтвортой байдлыг дэмжих зорилготой.

- Хуульд дижитал платформоор дамжуулан бичил зээлийн үйлчилгээ үзүүлдэг этгээдүүдийг дижитал бичил санхүүгийн зээлдүүлэгчид гэж тодорхойлсон. Үүнд зээлийн хүсэлт, баталгаажуулалт, олголт, болон гар утас эсвэл бусад дижитал сувгуудаар дамжуулан төлбөрийг хүлээн авах зэрэг үйл ажиллагаанууд орно.
- Хуульд дижитал бичил санхүүгийн зээлдүүлэгчдэд зээлийн хүү, төлбөр, төлбөрийн хуваарь, болон хожимдуулсан төлбөрийн торгууль зэрэг зээлийн холбогдох бүх нөхцөлийг мэдээлэхийг шаарддаг. Энэ нь зээлдэгчид зээлийн өртөг, үүргийн талаар бүрэн ойлголттой болохыг баталгаажуулдаг.
- Хуульд зээлдэгчийг шударга бус зээл олголтын үйл ажиллагаанаас хамгаалах тусгай заалтуудыг агуулдаг. Энэ нь зээл олголтын нөхцөлийг тодорхой мэдээлэхийг шаарддаг ба хэт өндөр хүүгийн хураамжийг хязгаарлахыг шаарддаг.

- ВОТ нь бичил санхүүгийн байгууллагууд, финтек зээлдүүлэгчдийг хянах, тэднийг хуулийн дагуу ажиллах, санхүүгийн тогтвортой байдлыг хангахыг баталгаажуулах үүрэгтэй. Хууль нь финтек зээлдүүлэгчдийг ВОТ-д үйл ажиллагааны болон хэрэглэгчийг хамгаалах арга хэмжээнүүдийн талаар тогтмол тайлан гаргаж өгөхийг шаарддаг.

Эдгээр зохицуулалт нь тус улсад финтек зээлийн зохицуулалтын бат бэх тогтолцоог бүрдүүлж, инновацыг дэмжихийн зэрэгцээ хэрэглэгчдийн эрхийг хамгаалж, санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг.

Танзани Улсын финтек зээлийн зохицуулалтын үндсэн зарчмууд

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах: ВОТ нь ил тод байдал, хүү болон шимтгэлийн мэдээллийг дэлгэрэнгүйгээр гаргах, хэрэглэгчидтэй шударга байдлаар харьцах зэрэг бүх төрлийн хэрэглэгчийн эрхийг хамгаалах журмуудыг хэрэгжүүлдэг. Финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгчид бүх холбогдох мэдээллийг хэрэглэгчдэд ойлгомжтой, энгийн хэлээр хүргэж, хэрэглэгчдэд мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргах боломжийг хангах ёстой.

Өрийн дарамтад орохоос сэргийлэх: Өрийн дарамтад орох эрсдэлийг бууруулахын тулд ВОТ нь зээлдэгчийн төлбөрийн чадварыг үнэлэхэд зээлийн мэдээллийн байгууллагуудыг ашиглахыг зөвлөж, зээлийн боломжит хэмжээг нээлттэй мэдээлэхээс зайлсхийхийг дэмждэг. Энэ нь зээлдэгчийн зээлийн хэмжээг хэтрүүлэхээс сэргийлэх арга хэмжээ юм. Мөн зээлийг хүсэлт илгээгээгүй байхад санал болгох болон хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр зээлийн хэмжээг автоматаар нэмэгдүүлэх үйлдлүүдийг хориглодог.

Мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал: ВОТ нь финтек зээлийн үйлчилгээ үзүүлэгчдэд хэрэглэгчийн өгөгдлийг хамгаалахын тулд хүчтэй аюулгүй байдлын арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийг шаарддаг. Үйлчилгээ үзүүлэгчид гуравдагч этгээдтэй өгөгдөл хуваалцахын өмнө хэрэглэгчийн зөвшөөрлийг авах ёстой бөгөөд хувийн нууцын хуулиудыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Хариуцлагатай үнэ тогтоох: Танзани Улсад финтек зээлийн хүүгийн хязгаар тогтоогдоогүй ч ВОТ нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэгчдийн ногдуулж буй хүүг шударга, үндэслэлтэй эсэхийг хянадаг.

Инновац болон уян хатан байдал: ВОТ-ийн “суралцан турших” аргачлал нь инновацыг дэмжихийн зэрэгцээ эрсдэлийг удирдах зохицуулалтын орчныг бүрдүүлсэн. Энэ уян хатан хандлага нь үйлчилгээ хүрээгүй оролцогчдод бодит финтек зээлийн зах зээлийг хөгжүүлэх боломжийг олгосон.

Танзани Улсын финтек зээлийн зохицуулалтын хүрээ нь инновацыг, хэрэглэгчийн эрх хамгаалах, санхүүгийн тогтвортой байдалтай үр дүнтэйгээр тэнцвэржүүлж байна. Танзани Улс Төв банкны тухай хууль, Цахим мөнгөний зохицуулалт, Бичил санхүүгийн тухай хууль зэрэг чухал зохицуулалтуудаар дамжуулан санхүүгийн хүртээмжийг ихээхэн нэмэгдүүлсэн, эрчимтэй хөгжиж буй дижитал санхүүгийн экосистемийг бий болгож чадсан. Танзани улсын төв банкны «Суралцан турших» арга барил нь финтек зээлийг хариуцлагатайгаар өргөжүүлэх, ил тод байдал, шударга үнэ тогтоолт, хэрэглэгчийг хамгаалах баталгааг хангах боломжийг олгож байна. Тус улсын туршлага нь дижитал санхүүгийн системийг хөгжүүлэх эсвэл сайжруулахыг эрмэлзэж буй бусад улс орнуудад үнэтэй туршлага болж өгдөг.

ИХ БРИТАНИ УЛСЫН ФИНТЕК ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Их Британи Улс санхүүгийн үйлчилгээний салбарт дэлхийд тэргүүлэгч байсаар ирсэн бөгөөд финтек зээлийн зах зээл ч мөн адил юм. Энэ зах зээл нь олон төрлийн финтек зээлийг хамарч, түүний дотор хэрэглэгчээс хэрэглэгч рүү (P2P) зээл болон финтек компаниудын шууд санал болгож буй финтек зээлүүдийг багтаадаг. Зах зээлийн хурдацтай өсөлт нь хэрэглэгчдийн хурдан, хүртээмжтэй зээлийн эрэлт хэрэгцээ болон зээлийн үйл явцыг хялбарчлах технологийн инновацуудаар өдөөгдөж байна.

Зохицуулагч байгууллагуудын үүрэг

Их Британи Улсад финтек зээлийн зах зээлийг хэд хэдэн гол байгууллага хяналт тавьдаг бөгөөд зээлдэгчдийн аюулгүй, ил тод, шударга орчинд ажиллаж байгааг хянах үүрэгтэй.

Их Британийн Санхүүгийн зохицуулагч байгууллага (FCA): Их Британийн Санхүүгийн зохицуулагч байгууллага (FCA) нь Их Британи Улсад финтек зээлийн үйл ажиллагааг голлон хянадаг зохицуулагч байгууллага юм. Энэ байгууллага нь хэрэглэгчдийг хамгаалах, зах зээлийн шударга байдлыг хангах, өрсөлдөөнийг дэмжих үүрэгтэй. FCA нь финтек зээл олгогчдод зориулсан дүрэм журам тогтоох, хяналт тавих, мөн дүрэм зөрчсөн компаниудад арга хэмжээ авах үүрэгтэй.

Английн төв банк (BoE): Английн төв банк нь үндсэндээ мөнгөний бодлого болон санхүүгийн тогтвортой байдалд анхаарлаа хандуулдаг боловч санхүүгийн тогтолцооны өргөн хүрээнд финтек зээлийн салбарыг багтааж FCA-тай хамтран ажилладаг. Английн төв банк нь финтек зээлийн зах зээлээс үүдэлтэй системийн эрсдэлийг хянаж, эдгээр нь санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал алдагдуулахгүй болохыг баталгаажуулдаг.

Мэдээллийн Комиссарын Газар (ICO): Энэхүү газар нь ЕХ-ны Ерөнхий Мэдээллийн Хамгаалалтын Дүрмийн (GDPR) дагуу мэдээллийн хамгаалалтын зохицуулалтыг хэрэгжүүлдэг. Энэ нь финтек зээл олгогчид хэрэглэгчдийн өгөгдлийг цуглуулах, боловсруулах, хадгалах талаар мэдээллийн нууцлалын стандартыг мөрдөхийг шаарддаг.

Финтек зээлийн зохицуулалтын тогтолцоо

Санхүүгийн Үйлчилгээ ба Зах Зээлийн Хууль 2000 (FSMA): FSMA нь Их Британи Улсын санхүүгийн зохицуулалтын үндсэн хууль бөгөөд үүгээр FCA ажилладаг эрх зүйн хүрээг бий болгодог. Тус хуулиар финтек зээлийн үйлчилгээ эрхлэгч байгууллагууд нь FCA зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулах шаардлагатай FSMA нь FCA-д ёс зүйн дүрэм тогтоох, компаниудыг хянах, шаардлагатай үед сахилгын арга хэмжээ авах эрх мэдлийг олгодог.

Хэрэглээний зээлийн хууль 1974: Энэ хууль нь Их Британи Улсад хэрэглээний зээлийг зохицуулдаг бөгөөд финтек зээллэгийн үйл ажиллагааны ихэнх хэсэгт хамаардаг. Энэ нь сурталчилгаанд ил тод байдлыг хангах, нөхцөл болзлыг тодорхой байлгах мөн зээлдэгчдийн эрхийг тодорхойлох шаардлагыг тогтоодог. Финтек зээл олгогчид эдгээр заалтуудыг мөрдөж бүх зээлийн гэрээ шударга байх бөгөөд хэрэглэгчид өөрсдийн үүрэг хариуцлагаа бүрэн мэддэг байх ёстой.

P2P зээлийн зохицуулалт: 2014 онд FCA нь P2P зээлийн платформуудын тусгай зохицуулалтыг нэвтрүүлсэн бөгөөд энэ салбарын онцлог эрсдэл болон боломжуудыг хүлээн зөвшөөрсөн. Эдгээр зохицуулалтуудад дараах зүйлс багтана:

- Харилцагчийн мөнгөн хөрөнгийн

дүрэм (Client Money Rules): P2P платформууд харилцагчийн хөрөнгийг платформын үйл ажиллагааны хөрөнгөөс тусгаарлан хадгалах ёстой бөгөөд ингэснээр платформ дампуурах тохиолдолд хөрөнгө оруулагчдын мөнгийг хамгаалах зорилготой.

- *Мэдээлэл ил тод байдлын шаардлага:* P2P зээлийн платформууд нь P2P үйл ажиллагааны явцад үүсэж болзошгүй эрсдэлүүдийн талаар тодорхой, дэлгэрэнгүй мэдээлэл өгөх үүрэгтэй.
- *Өөрийн хөрөнгийн шаардлага:* P2P платформууд нь боломжит алдагдлыг нөхөх болон платформын тогтвортой байдлыг хангахын тулд хангалттай хэмжээний хөрөнгийн нөөцтэй байх ёстой.

Их британи Улсад Мэдээлэл хамгаалах тухай хууль 2018 он (Data Protection Act 2018)–аар дамжуулан финтек зээл олгогчдод хувийн мэдээллийн тал дээр шалгуур хатуу зохицуулалттай. Зээл олгогчид мэдээллийг хууль ёсны, ил тод, зайлшгүй шаардлагатай хүрээнд цуглуулах ёстой. Хэрэглэгчид өөрсдийн мэдээлэлд хандах эрхтэй бөгөөд тэдгээрийг засварлах, тодорхой нөхцөлд устгуулах эрхтэй. Мэдээллийн комиссарын газар (ICO) нь Ерөнхий мэдээллийн хамгаалалтын дүрэм (GDPR)–ийг хэрэгжүүлэх үүрэгтэй бөгөөд дүрэм зөрчсөн тохиолдолд их хэмжээний торгууль ногдуулж болно.

Мөнгө угаахтай тэмцэх (AML) болон Харилцагчийг таньж мэдэх (KYC) журам: Их Британи Улсад финтек зээл олгогчид AML болон KYC–ийн хатуу шаардлагыг дагаж мөрдөх ёстой. Эдгээр зохицуулалтууд нь зээл олгогчид харилцагчдаа баталгаажуулж, сэжигтэй үйлдлүүдийг хянах замаар мөнгө угаах болон террорист үйл ажиллагааны санхүүжилтээс сэргийлэхэд чиглэгдсэн.

Финтек зээлийн зохицуулалтын шинэчлэлтүүд:

FCA–ийн дижитал маркетинг ба санхүүгийн сурталчилгааны талаарх зөвлөмж: Сүүлийн жилүүдэд FCA нь санхүүгийн үйлчилгээний салбарт дижитал маркетингтай холбоотой эрсдэлүүдийг шийдвэрлэх тусгай зөвлөмжийг гаргасан. Энэ зөвлөмж нь финтек зээл олгогчид санхүүгийн сурталчилгаануудыг тодорхой, шударга, төөрөгдүүлэхгүй байхыг шаарддаг. FCA нь эдгээр стандартад нийцэхгүй сурталчилгааг хориглох, төөрөгдүүлсэн сурталчилгаа явуулсан компаниудад арга хэмжээ авах эрхтэй.

“Одоо аваад, дараа нь төл” (BNPL) зохицуулалт: BNPL үйлчилгээ нь түгээмэл болсноор Их Британи Улсын Засгийн Газар болон FCA нь хэрэглэгчдийг хамгаалахын тулд зохицуулалт шаардлагатайг хүлээн зөвшөөрсөн. FCA нь BNPL бүтээгдэхүүнийг зохицуулалтын хүрээнд оруулах төлөвлөгөөг зарласан. Ингэснээр зээл олгогчид бусад төрлийн зээлтэй адил ил тод байдал, төлбөрийн чадварыг шалгах, хэрэглэгчийн хамгааллын стандартыг мөрдөх шаардлагатай болно.

Үйл ажиллагааны тогтвортой байдлын шаардлага: Санхүүгийн үйлчилгээний салбарт технологийн хамаарал өсөн нэмэгдэж байгаатай холбогдуулан FCA нь Английн Банктай хамтран үйл ажиллагааны тогтвортой байдлын шинэ дүрмүүдийг нэвтрүүлсэн. Эдгээр дүрэм нь финтек зээл олгогчдыг үйл ажиллагааны эрсдэлүүдийг тодорхойлж, удирдах, мөн кибер аюул занал зэрэг эрсдэлүүдийг хянаж, тасалдал үүссэн үед үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх боломжтой байхыг шаарддаг.

Их Британи Улсын финтек зээлийн зах зээлийн сорилт, эрсдэлүүд

Мэдээллийн аюулгүй байдал ба нууцлал: Финтек зээл олгогчдын боловсруулж буй хувийн мэдээллийн хэмжээ нэмэгдэхийн

хэрээр мэдээллийн алдагдлын эрсдэл томоохон асуудал хэвээр байна. GDPR-ийн шаардлагыг биелүүлэх нь чухал ч, кибер аюул заналууд хувьсан өөрчлөгдөж байгаа нь аюулгүй байдлын арга хэмжээнд байнгын анхаарал хандуулж, хөрөнгө оруулалт хийх шаардлагатай байна.

Хэрэглэгчийг хамгаалах: Финтек зээлийн бүтээгдэхүүнүүд нарийн төвөгтэй болохын хэрээр хэрэглэгчид нөхцөл болзлыг бүрэн ойлгох нь сорилт хэвээр байна.

Их Британи Улсад финтек зээлийн үйл ажиллагааг зохицуулж буй хүрээ нь бат бөх,

цогц бөгөөд хэрэглэгчийг хамгаалахын зэрэгцээ инновацыг дэмжихэд чиглэсэн. FCA нь финтек зээлийн үйл ажиллагааг шударга, ил тод, аюулгүй байлгах үүрэгтэй төв байгууллага юм. Зах зээл цаашид хөгжихийн хэрээр, одоо байгаа дүрмүүдийг шинэчлэх болон хэрэгжүүлэх нь энэ салбарын шударга байдлыг хадгалахад Зохицуулагч байгууллага чухал үүрэг гүйцэтгэдэг. Их Британи Улсын финтек зээлийг зохицуулах арга барил нь бусад улс орнуудад өөрсдийн финтек зээлийн зах зээлийг хөгжүүлэх болон хянахад чухал загвар болж байна.

ЭНЭТХЭГ УЛСЫН ФИНТЕК ЗЭЭЛИЙН ЗОХИЦУУЛАЛТ

Энэтхэг Улсын финтек зээлийн зах зээл сүүлийн арван жилд хурдацтай өсөлттэй байсан ба үүнийг ухаалаг гар утас болон интернэтийн өргөн хэрэглээ, мөн санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын санаачилгууд өдөөсөн юм. Энэ зах зээл нь хувийн зээл, жижиг, дунд бизнесийн (SME) санхүүжилт, “Одоо аваад, дараа нь төл” (BNPL) зэрэг олон төрлийн бүтээгдэхүүнийг хамардаг бөгөөд эдгээрийг уламжлалт банкнууд, банк бус санхүүгийн компаниуд (NBFCs) болон финтек гарааны бизнесүүд үйлчилгээ үзүүлдэг. 2030 он гэхэд энэ зах зээл нь 1.3 их наяд ам.долларын боломжийг бий болгоно гэж тооцоолж байгаа² бөгөөд энэ нь асар их нөөц бололцоо байгааг харуулж байна.

Энэтхэгийн финтек зээлийг зохицуулдаг гол байгууллага бол Энэтхэгийн Төв Банк юм. Энэ байгууллага нь бодлогын ерөнхий хүрээг тогтоож, удирдамж гарган, санхүүгийн байгууллагуудын хэрэгжилтийг хянадаг. RBI-ийн хандлага нь инновацыг дэмжиж, хэрэглэгчийг хамгаалах, санхүүгийн тогтвортой

байдалтай тэнцвэржүүлэхэд чиглэгддэг.

Финтек зээлийн зохицуулалтын тогтолцоо

1. банк бус санхүүгийн байгууллагуудын (NBFCs) зохицуулалт:

- *Master Directions on NBFCs:* Энэтхэгийн Төв Банк нь финтек зээлийн экосистемийн гол тоглогчид болох NBFC-ийг зохицуулсан цогц удирдамж гаргасан. Эдгээр зохицуулалтууд нь хамгийн бага хөрөнгийн шаардлага, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх хэм хэмжээ, хэрэглэгчийг таних үйл явц зэрэг асуудлуудыг хамардаг.
- *Банк бус санхүүгийн байгууллагуудын P2P удирдамж:* Энэ удирдамж нь тус улсад финтек зээлийн чухал бүрэлдэхүүн хэсэг болох хэрэглэгчээс хэрэглэгч рүү (P2P) зээлийн платформуудыг зохицуулдаг. Удирдамжид платформуудын Энэтхэгийн Төв Банк (RBI)-д

² https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN_ID4558960_code5910975.pdf?abstractid=4558960&mirid=1&type=2

бүртгүүлэх шаардлага, зээлдэгч болон зээл олгогчийн эрсдэлийг хязгаарлах шаардлага, мөн заавал эскроу данс ашиглах шаардлага зэрэг орсон.

2. Финтек зээлийн удирдамж 2022: Мэдээллийн нууцлал, ёс зүйгүй өр барагдуулах зэрэг асуудлууд нэмэгдэж байгаатай холбогдуулан, Энэтхэгийн Төв Банк (RBI) 2022 онд Финтек зээлийн удирдамжийг танилцуулсан. Энэхүү удирдамжийн гол заалтуудад дараах зүйлс багтана:

- *Ил тод байдал ба мэдээлэл өгөх:* Финтек зээл олгогчид бүх зээлийн нөхцөл, үүнд хүү, шимтгэл, торгууль зэргийг тодорхой мэдээлэх үүрэгтэй. Удирдамжийн дагуу зээл олгогчид эдгээр нөхцөлийг тусгасан стандарт Баримт Бичиг (Key Fact Statement, KFS)-ийг зээлдэгчдэд гаргаж өгөх шаардлагатай.
- *Зөвшөөрөлд суурилсан мэдээлэл цуглуулалт:* Тус улсын финтек зээл олгогчид хэрэглэгчдийн хувийн мэдээллийг цуглуулж, ашиглахаасаа өмнө тэдний тодорхой зөвшөөрлийг заавал авах ёстой. Удирдамж нь хэрэглэгчийн зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд мэдээллийг дамжуулахыг хязгаарладаг бөгөөд зөвхөн зээлийн үйл явцыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тохиолдолд, хэрэглэгчийн зөвшөөрлийн үндсэн дээр л мэдээллийг хуваалцах боломжтой.
- *Гомдол шийдвэрлэх механизм:* Финтек зээл олгогчдыг хэрэглэгчдийн гомдлыг цаг алдалгүй, үр дүнтэй шийдвэрлэх боломжийг хангахын тулд гомдол шийдвэрлэх механизм байгуулахыг удирдамж нь шаарддаг. Энэхүү механизм нь зээлдэгчид гарсан

аливаа асуудлыг түргэн шуурхай шийдвэрлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй.

3. Зохицуулалтын сэндроксын орчин: Энэтхэгийн Төв Банкны Зохицуулалтын Сэндрокс орчны санаачилга нь финтек компаниудад шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээг хянагч байгууллагын хяналттай орчинд турших боломжийг олгодог. Энэ санаачилга нь шинэ бүтээгдэхүүнүүдийг хэрэглэгчдийн аюулгүй байдлыг хангахын зэрэгцээ одоо байгаа зохицуулалтуудтай нийцүүлэхэд чиглэгдсэн.

4. Мэдээлэл технологийн дүрэм 2011 он: Энэхүү дүрэм нь 2000 оны Мэдээллийн технологийн тухай хуульд үндэслэн гарсан бөгөөд финтек зээлдэгчийн санхүүгийн мэдээллийг хэрхэн зохицуулахыг зааж өгсөн. Зээлдэгчид мэдээллийг хамгаалахын тулд зохистой аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлж, хувийн мэдээлэл цуглуулах эсвэл боловсруулахын өмнө мэдэгдэж зөвшөөрөл авах ёстой.

5. Хувийн мэдээллийн хамгаалах хууль (Санал): Санал болгож буй Хувийн мэдээллийн хамгаалах хууль нь Энэтхэгт мэдээллийн хамгаалалтын талаар цогц хууль эрх зүйн хүрээг бий болгоход чиглэгдсэн. Хуулийг хэрэгжүүлснээр финтек зээл олгогчдод хувийн мэдээллийг цуглуулах, боловсруулах, хадгалахтай холбоотой илүү хатуу үүрэг хүлээлгэх болно. Энэ хууль нь мэдээллийг дотооддоо хадгалах, хэрэглэгчийн зөвшөөрөл авах, мэдээллийн алдагдалд ногдуулах торгуулийн заалтуудыг багтаасан.

Энэтхэг Улсын финтек зээлийн зах зээлийн сорилт

Мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал: Финтек зээл олгогчид асар их хэмжээний хувийн мэдээлэл цуглуулж, боловсруулдаг

тул мэдээллийн хамгаалалтын зохицуулалтыг мөрдөх нь нэн чухал шаардлагатай. Хувийн өгөгдлийн хамгаалалтын хууль нь мэдээллийг хэрхэн зохицуулах талаар илүү хатуу зохицуулалтыг нэвтрүүлж, зөрчигдсөн тохиолдолд их хэмжээний торгууль ногдуулах төлөвтэй байна.

Залилан мэхлэлт: Финтек зээлийн хурдацтай өсөлт нь зохицуулагдаагүй аппликейшн болон платформуудын өсөлтийг өдөөсөн бөгөөд зарим нь залилан мэхлэх эсвэл ёс зүйгүй үйл ажиллагаа явуулдаг байна. Энэтхэгийн Төв Банк зөвшөөрөлтэй финтек зээлийн платформуудын цагаан жагсаалтыг гаргах, салбарын хяналтыг нэмэгдүүлэх зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Өрийн дарамт: Зээлийн оноог үнэлэхэд ашигладаг хувилбар мэдээлэл нь шинэлэг боловч зөв зохицуулагдаагүй тохиолдолд эрсдэл учруулж болзошгүй юм. Зээлдэгчдийн эргэн төлөх чадварыг үнэн зөвөөр тусгахын тулд зээлийн үнэлгээний загваруудыг тасралтгүй хянах, шинэчлэх шаардлагатай. Энэтхэгийн Төв Банкны зээлдэгчийн эрсдэлийг хязгаарлах удирдамж нь эдгээр эрсдэлүүдийг бууруулахад чиглэгдсэн.

Зохицуулалтын шаардлага болон үйл ажиллагааны эрсдэлүүд: Финтек зээл олгогчид олон төрлийн удирдамжийг дагаж мөрдөх, мөн үйл ажиллагаагаа технологийн доголдлоос хамгаалах зэрэг томоохон зохицуулалтыг хэрэгжүүлэх шаардлагатай тулгардаг. Энэтхэгийн Төв Банкны үйл ажиллагааны тогтвортой байдал болон кибер аюулгүй байдалд тавьж буй анхаарал нь эдгээр сорилтуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм.

Финтек зээлийн ирээдүйн хандлага

IndiaStack-тай нэгтгэх: IndiaStack нь цаасгүй гүйлгээ, дижитал үнэмлэх баталгаажуулдаг Программын интерфэйс (API)-уудын багц

бөгөөд энэ нь финтек зээлийн экосистемд салшгүй чухал юм. Финтек зээлийн платформуудыг IndiaStack-тэй нэгтгэх нь үр ашгийг нэмэгдүүлж, зардлыг бууруулж, зээлд хамрагдах боломжийг өргөжүүлэх боломжтой.

Угсармал санхүү: Угсармал санхүү нь санхүүгийн үйлчилгээг санхүүгийн бус платформууд (жишээлбэл, цахим худалдааны веб сайтууд) дээр шууд нэгтгэх явдал бөгөөд энэ үйл явц тус улсад эрчимтэй явагдаж байна. өсөн нэмэгдэж байна. Энэ загвар нь хэрэглэгчдэд зээлийн хэрэгцээ гарсан үед шууд зээл авах боломжийг олгож, санхүүжилтийг илүү хялбар, тохиромжтой болгох болно.

Тогтвортой санхүү: Зарим финтек зээл олгогчид байгаль орчинд ээлтэй төслүүдийн ногоон зээл болон санхүүжилтийн боломжуудыг санал болгож эхэлж байгаа бөгөөд энэ нь тогтвортой санхүүгийн дэлхийн хандлагад нийцэж байна. Хэрэглэгчид болон бизнесүүд байгаль орчны асуудлыг нэн тэргүүнд тавьж эхэлж байгаа тул тогтвортой байдалд чиглэсэн анхаарал цаашид улам бүр нэмэгдэх төлөвтэй байна.

Энэтхэгийн финтек зээлийн салбар нь шинэлэг санаачилга, чухал зохицуулалтын хяналт, мөн хэрэглэгчийн эрхийг хамгаалахад анхаарал хандуулдаг. Энэтхэгийн Төв Банк нь зохицуулалтын орчныг бүрдүүлэхэд гол үүрэг гүйцэтгэж, инновац болон санхүүгийн тогтвортой байдлыг тэнцвэржүүлж ажилладаг. Зах зээл цаашид хөгжихийн хэрээр, Хувийн өгөгдөл хамгаалалтын тухай хууль зэрэг шинэ зохицуулалтын хүрээг нэвтрүүлж, одоо байгаа зохицуулалтыг шинэчлэх нь финтек зээлийг аюулгүй, ил тод, бүх оролцогч талуудад үр өгөөжтэй байлгахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

IV. АFI-ИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ФИНТЕК ЗЭЭЛИЙГ ДЭМЖИХ 10 ЗАРЧИМ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Финтек зээлийг дэмжих 10 зарчим	Танзани Улс	Их Британи Улс	Энэтхэг Улс	Монгол Улс
Эрх зүйн бүртгэл, зохицуулалтын хүрээ	Танзанийн Төв Банк (BOT) нь голчлон уламжлалт санхүүгийн байгууллагуудад төвлөрсөн байдаг ч финтек зээл олголтыг хянах зохицуулалтыг нэвтрүүлэн хөгжүүлж байна	Санхүүгийн Зохицуулах Газар (FCA) нь финтек зээл болон P2P зээл олгох платформуудад зориулсан зохицуулалттай.	Энэтхэгийн Төв банк (RBI) нь финтек зээлийн зохицуулалттай 2022 онд Финтек зээлийн удирдамжийг боловсруулсан.	СЗХ финтек зээл олгодог байгууллагуудыг зохицуулдаг.
Байгууллагын чадавх	BOT нь финтек зээлийг хянах үүрэгтэй нэгжүүдтэй.	FCA нь санхүүгийн, технологи болон хэрэглэгчийн хамгаалалтад тусгайлан мэргэшсэн нэгжүүдтэй.	RBI нь финтек зээлийг хянах үүрэгтэй нэгжүүдтэй.	СЗХ нь финтек зээлийг хянах үүрэгтэй нэгжтэй.
Зээлийн цогц, үр дүнтэй мэдээллийн систем	Зээлийн мэдээллийн сан хөгжиж байгаа бөгөөд, цахим мөнгөний мэдээллийг нэгтгэх үйл явц үргэлжилж байна.	Зээлийн мэдээллийн агентлагууд ажилладаг ба FCA хяналт тавьж ажилладаг. Өргөн хүрээтэй өгөгдөлд суурилсан бат бөх зээлийн онооны загваруудтай.	Зээлийн мэдээллийн байгууллагууд ажилладаг ба RBI нь мэдээлэл цуглуулах, тайлагнах, хэрэглэгчийн эрхийг хангах стандартыг тогтоодог.	Зээлийн мэдээллийн агентлагууд ажилладаг ба төв банк хяналт тавьж ажилладаг.
Ил тод байдал	Ил тод байдлыг шаарддаг зохицуулалттай	FCA нь Хэрэглэгчийн зээлийн тухай хуулийн дагуу ил тод, иж бүрэн мэдээлэл өгөхийг шаарддаг.	Финтек зээлийн удирдамжид зааснаар зээлдүүлэгчдийг зээл авахаасаа өмнө хэрэглэгчдэд шаардлагатай бүх мэдээллийг багтаасан стандартчилсан Key Fact Statement (KFS) хүснэгтийг өгөхийг шаарддаг.	Ил тод байдлыг шаарддаг.
Салбарын ёс зүйн дүрэм	Зохицуулагч байгууллагуудын дэмжлэгтэйгээр салбарын ёс зүйн дүрмийг хөгжүүлж байгаа ч бүрэн албан ёсны болоогүй байна.	FCA нь санхүүгийн үйлчилгээний салбарт ёс зүйн дүрмийг сайн хангуулсан.	RBI нь Шударга практикийн кодыг хэрэгжүүлж, Энэтхэгийн Финтек зээлдүүлэгчдийн Холбоо (DLAI) зэрэг салбарын холбоод ёс зүйн стандартыг сурталчилдаг.	Салбарын ёс зүйн дүрмийг хөгжүүлж байгаа.

Мэдээллийн хамгаалалт, нууцлал	Хэрэглэгчийн мэдээллийн хамгаалах зорилгоор хэд хэдэн хуулийн заалтууд байдаг. GDPR шиг иж бүрэн мэдээлэл хамгаалах хууль байхгүй.	Европын Холбооны GDPR Мэдээлэл хамгаалах хуулиар зохицуулагддаг бөгөөд өгөгдөл хамгаалалт болон аюулгүй байдлын хатуу стандартыг хангадаг.	Ойрын хугацаанд батлагдах Хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн төсөл нь финтек зээлдүүлэгчдэд илүү олон шаардлага мөрдүүлэх төлөвтэй байна. Одоогоор RBI-ийн удирдамжаар зохицуулагдаж байгаа.	ISO 27001 стандартыг мөрдөхийг шаарддаг.
Луйвар, кибер аюулгүй байдал, тогтвортой байдал	Кибер аюулгүй байдлын протоколыг дагах мөн тогтмол аудитад хамрагдахыг шаарддаг	Үндэсний Кибер Аюулгүй Байдлын Төв (NCSC) нь санхүүгийн байгууллагуудын кибер аюулгүй байдалд дэмжлэг үзүүлдэг.	RBI нь санхүүгийн байгууллагуудад тогтмол аюулгүй байдлын аудит хийх мөн нөөц төлөвлөгөөтэй байхыг шаарддаг.	Төр болон хувийн байгууллагуудын хамтын ажиллагаа сайжирч байгаа, Мөн тогтмол аудитад хамрагдахыг шаарддаг
Дижитал санхүүгийн боловсрол	Санхүүгийн боловсролыг сайжруулах зорилгоор хэд хэдэн үндэсний төсөл хөтөлбөрүүд байдаг. Ихэвчлэн хөдөөгийн бүс нутгууд руу чиглэгддэг.	Хэрэглэгчдэд дижитал санхүүгийн үйлчилгээний талаар боловсрол олгох олон санаачилга хэрэгжиж байна. FCA өөрөө хэрэглэгчдэд эрхээ хамгаалах, финтек зээлтэй холбоотой эрсдэлүүдийн талаар мэдээлэл өгөхөд оролцдог.	Санхүүгийн боловсролын үндэсний стратеги (NSFE) улсын хэмжээнд санхүүгийн боловсролыг сайжруулах цогц төлөвлөгөө юм. RBI болон Засгийн газар нь санаачлан цахим санхүүгийн боловсролыг өргөн хүрээтэй дэмждэг.	Санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх стратеги улсын хэмжээнд санхүүгийн боловсролыг дэмжих бодлоготой
Өрсөлдөөн, хамтын ажиллагаа	Хэд хэдэн холбоод байдаг бөгөөд банкнууд, финтек компаниуд болон зохицуулагчдын хооронд яриа хэлэлцээрийг хөнгөвчилж, ашиг сонирхлыг уялдуулах, хамтын ажиллагааны орчныг бүрдүүлэхэд тусалдаг. Сэндбоксийн орчныг нэвтрүүлсэн.	Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дижитал санхүүгийн экосистемийг хөгжүүлэхийн тулд нийтийн болон хувийн хэвшлийн түншлэлийг дэмждэг. Сэндбоксийн орчныг нэвтрүүлсэн.	Цахим зээлийн зах зээл нь өндөр өрсөлдөөнтэй бөгөөд уламжлалт банкнуудтай нягт хамтран ажилладаг. Сэндбоксийн орчныг нэвтрүүлсэн.	Банкнууд болон финтек компаниудын хоорондын хамтын ажиллагаа хөгжиж байгаа. Сэндбоксийн орчныг нэвтрүүлсэн.
Гомдол, шийдвэрлэх систем	Үндсэн гомдол шийдвэрлэх механизм үүссэн бөгөөд аль ч хэлбэрээр гомдол гаргаж болно. BOT нь гомдлуудыг хянадаг.	Санхүүгийн байгууллагууд FCA-д гомдлуудыг тайлагнах үүрэгтэй. Хараат бус байгууллага болох Financial Ombudsman Service (FOS) мөн оролцдог.	Гомдол шийдвэрлэх системийг хөгжүүлсэн. Online Dispute Resolution (ODR) мөн Banking Ombudsman нэвтрүүлсэн.	Гомдол, маргаан шийдвэрлэх системүүд хөгжүүлж байгаа.

Танзани, Их Британи, Энэтхэг, Монгол Улсуудыг АFI-ийн “Хариуцлагатай финтек зээлийн зохицуулалтын хүрээ”-г ашиглан харьцуулан шинжиллээ. Тус бүрийн эдийн засгийн өвөрмөц нөхцөл байдал болон зохицуулалтын хөгжлийн үе шат нь харьцангуй ялгаатай байна.

Танзани Улс нь финтек зээлийн зохицуулалтын хүрээгээ бүрдүүлэх эхний үе шатандаа явж байна. Танзанийн төв банк (BOT) нь «Суралцан турших» стратегийг ашиглаж, зохицуулалтын хүрээнд ахиц гаргасан боловч байгууллагын чадавх, зээлийн мэдээллийн систем, мэдээллийн хамгаалалт болон кибер аюулгүй байдлыг бүрэн хөгжүүлэх тал дээр зарим сорилтуудтай тулгарсаар байна. Танзани Улс санхүүгийн боловсролыг сайжруулах, уламжлалт санхүүгийн байгууллагууд болон финтек компаниудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих тал дээр амжилттай ахиц гаргаж байгаа ч эдгээр хүчин чармайлтуудыг бүрэн дүүрэн ашиглахын тулд цаашид зохицуулалтын хүрээгээ сайжруулах шаардлагатай байна.

Их Британи Улс нь боловсронгуй болсон зохицуулалтын орчинтой бөгөөд ил тод байдал, хэрэглэгчийг хамгаалах, мэдээллийн нууцлалд илүү анхаарал хандуулдаг. Санхүүгийн Зохицуулах Газар (FCA) нь финтек зээлийн зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, аюулгүй байлгах нөхцөлийг бүрдүүлдэг бөгөөд үүнд зээлийн лавлагааны систем болон бат бөх гомдол шийдвэрлэх механизм ордог. Их Британи Улс нь инновацыг нарийн хяналттай уялдуулан зохицуулдаг тул аюулгүй, хүртээмжтэй дижитал санхүүгийн экосистемийг хөгжүүлэхийг зорьж буй бусад улс орнуудад үлгэр жишээ болж байна.

Энэтхэг Улс нь финтек зээлийн зах зээлийн хурдацтай өсөлтийг үр дүнтэй удирдахын тулд цогц, уян хатан зохицуулалтын хүрээг боловсруулсан. Энэтхэгийн Төв Банк (RBI) нь байгууллагын чадамжийг бүрдүүлж, дэвшилтэт зээлийн лавлагааны системүүдийг нэвтрүүлэн, ил тод байдал, мэдээллийн хамгаалалт, хэрэглэгчийн

боловсролд онцгой анхаарал хандуулж байна. Энэтхэгийн дижитал санхүүгийн боловсролын идэвхтэй дэмжлэг болон нэгдсэн гомдол шийдвэрлэх систем нь хэрэглэгчдийг мэдээллээр хангаж мөн эрхээ хамгаалах боломжийг олгож байна. Дижитал санхүүгийн орчинд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдан, мэдээллийн хамгаалалт болон кибер аюулгүй байдлын зохицуулалтыг тасралтгүй сайжруулах нь Энэтхэгийн санхүүгийн системд итгэлцэл, хүртээмжийг хадгалахад чухал үүрэг гүйцэтгэх болно.

Монгол улсын финтек зээлийн зохицуулалтын хүрээг судалж, Танзани, Их Британи, Энэтхэг зэрэг улсуудад ажиглагдсан шилдэг туршлагаудтай харьцуулсан шинжилгээ хийлээ. Монгол Улс финтек зээлийн зохицуулалтын орчныг бүрдүүлэх чиглэлээр ихээхэн ахиц гаргаж байна. Тиймээс цаашид зохицуулалтын орчныг сайн бүрдүүлсэн бусад улс орнуудын туршлагаас суралцах хэрэгтэй.

Финтек зээлийн зохицуулалтын үндсэн хүрээг бүрдүүлж, лиценз олгох, мэдээлэл хамгаалах, хэрэглэгчийн эрхийг хамгаалахад анхаарч байна. Гэсэн хэдий ч ил тод байдал болон зээлийн мэдээллийн системийн нэгтгэлийн чиглэлээр илүү нарийвчлан сайжруулах шаардлага байна. Жишээлбэл: Энэтхэгийн Key Fact Statements зэрэг стандарчлалыг нэвтрүүлэх

Байгууллагын чадавхыг бэхжүүлэх шаардлагатай. Энэ нь дижитал санхүүгийн үйлчилгээг үр дүнтэй хянах, зохицуулах тусгай нэгжүүдийг хөгжүүлэх болон технологийн чадамжийг сайжруулахыг багтаана.

Зээлийн мэдээллийн систем, мэдээлэл хамгаалалтын зохицуулалт, гомдол шийдвэрлэх систем үүсгэсэн хэдий ч цаашид сайжруулах хэрэгтэй. Их Британи болон Энэтхэгийн дэвшилтэт зохицуулалтуудаас суралцаж, хөгжүүлэх нь хариуцлагатай зээлийн практикийг сайжруулахад чухал ач холбогдолтой бөгөөд хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэх болно.

V. МОНГОЛ УЛСЫН ФИНТЕК ЗЭЭЛ БА ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль 2021 оны 5 сарын 21-ны өдөр батлагдаж 2021 оны 7 сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Энэ хуулийн 19 дүгээр Банкнаас олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Монголбанк, эрх бүхий хуулийн этгээдээс олгох зээлийн үйл ажиллагаатай холбогдсон журмыг Санхүүгийн зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина” гэж заасны дагуу зүйлийн 10-т 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 160 дугаар СЗХ-ны 160 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр хэсгийн 4.1-т Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дэвшилтэт технологийн шийдэл ашиглан цахим /цаашид “финтек” гэх/-аар зээлийн бүтээгдэхүүн гаргах тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-нд бүртгүүлнэ гэж заасан.

Финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлага

- Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 2,500,000,000 /хоёр тэрбум таван зуун сая/ төгрөгөөс доошгүй байх.
- ISO/ 27001 стандартыг хангасан Мэдээллийн аюулгүй байдлын аудитыг хийлгэж баталгаажуулсан байх;
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь финтек зээлийн бүтээгдэхүүний гэрээ байгуулж, шугам нээсэн тохиолдолд мэдээллийг тухай бүр Зээлийн мэдээллийн санд мэдээлнэ
- Финтек зээлийн бүтээгдэхүүний хувьд Хорооноос тогтоосон өр, орлогын харьцаа, эргэн төлөгдөх чадварыг

харгалзана

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь үйл ажиллагааны зардлаа бууруулах зорилгоор гуравдагч этгээдийн мэдээллийн технологийн системд холбогдон тухайн программ хангамжид боловсруулагдсан мэдээллийг ашиглан зээл олгох тохиолдолд Хороонд заавал урьдчилан мэдэгдэнэ. Гуравдагч этгээд нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасан шаардлагыг хангасан байна.
- Энэ журмын 4.1-д заасны дагуу финтек зээлийн бүтээгдэхүүнийг бүртгүүлсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.6, 17.1.7-д заасан үүргийг биелүүлж ажиллах ба холбогдох дүгнэлт, зөвлөмж, шаардлагын дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх тайлан, мэдээллийг дараа оны 3 дугаар сарын 31-ний өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

Цахим зөвлөл нь Финтек зээлийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт гаргах мөн чиг үүргийг хэрэгжүүлэхээс гадна дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1.1.ирүүлсэн баримт бичигтэй холбоотойгоор нэмэлт тодруулга, нэмэлт баримт бичиг шаардах;
- 3.1.2.хүсэлт гаргагчийн финтек зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэхгүй байх дүгнэлт гаргасан


тохиолдолд тухайн дүгнэлтийг үндэслэл, тайлбарыг гарган Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох нэгжид хүргүүлэх;

- 3.1.3.санхүүгийн зах зээлийн тогтвортой байдал алдагдах, харилцагчийг хохироох нь нотлогдох, холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг зөрчсөн

тохиолдолд холбогдох асуудлыг хэлэлцэн шуурхай арга хэмжээ авч хэрэгжүүлэх талаар Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох нэгжид дүгнэлт хүргүүлэх;

2023 оны байдлаар Цахим зөвлөл нийтдээ 7 удаа хуралдаж 46 хүсэлт ирүүлснээс 40 шаардлага хангасан аппликэйшнийг бүртгэсэн.

Зураг 5. Цахим зээлийн хөгжлийн үйл явц



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Финтек + уламжлалт үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ууд

Зураг 6. Финтек зээлийн бүтээгдэхүүн гаргасан ББСБ-уудын тоо



Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

2023 оны байдлаар Монгол улсад 529 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас Финтек уламжлалт үйл ажиллагаа эрхэлдэг 55 ББСБ-ын үүнээс зөвхөн технологид суурилсан 6 ББСБ байна. Салбарын хэмжээнд нийт хөрөнгө 4.7 их наяд төгрөг байгаа ба үүний 53.2 хувь буюу 2.5 их наяд төгрөгийг эдгээр 55 ББСБ бүрдүүлж байна. Финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа ББСБ-уудын ашигт ажиллагааг харвал 49 ББСБ нь нийт 225.8 тэрбум төгрөгийн ашигтай, 1 ББСБ нь тайлант онд ашиг болон алдагдалгүй, 5 ББСБ нь нийт 1.9 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Хүснэгт 2. Ашигт ажиллагаа

	1-ээс бага	1-5 хувь	5-10 хувь	10-аас дээш
Өөрийн хөрөнгийн өгөөж /ROE/	12.7%	9.1%	3.6%	74.5%
Нийт хөрөнгийн өгөөж /ROA/	12.7%	12.7%	12.7%	61.8%

Эх сурвалж: Судлаачийн боловсруулалт

Нийт финтекийн үйл ажиллагаа эрхэлдэг 55 ББСБ-ууд нийт зээлийн үлдэгдэл 758.5 тэрбум төгрөг буюу 20.6 хувь нь зөвхөн гар утсаараа дамжуулан зээл авч байна. Мөн жигнэсэн дундаж хүү 3.6 хувь байгаа нь салбарын жигнэсэн дундаж хүүг бодвол 0.3 пунктээр өндөр байна. Зээлийн ангиллаар авч үзвэл санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 91.0 хувийг хэвийн, 2.9 хувийг хугацаа хэтэрсэн, 6.1 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Салбарын хэмжээнд давхардсан тоогоор 4,535,672 харилцагч, 1,600,427 зээлдэгч байгаагаас харилцагчдын 94.1 хувь, зээлдэгчдийн 82.4 хувь нь эдгээр ББСБ-ын харилцагчид буюу технологид суурилсан зээлийн үйлчилгээг хүртэгсэд юм. Салбарын дундаж зээлийн хэмжээ 2,296.8 мянган төгрөг байгаа бол финтекийн зээлийн дундаж 575.2 мянган төгрөг байна.

Нийт олгосон зээл 7.2 их наяд төгрөг байгаагаас 73.5 хувь буюу 5.3 их наяд төгрөг нь эдгээр 55 ББСБ-ууд зээлж байна. Нийт 5.3 их наяд төгрөгийн зээл олгогдсоноос 92.5 хувь нь иргэнд, 7.5 хувь нь хуулийн этгээдэд олгосон зээл байна. Олгосон зээлийн 71.0 хувь нь 12 сар хүртэлх зээл зээлж байна. Иргэнд олгосон зээлийн 84.3 хувь нь хэрэглээний зээлд олгогдсон. Нийт хөрөнгийн өгөөж 10-аас дээш хувьтай 34 ББСБ, өөрийн хөрөнгийн өгөөж 10-аас дээш хувьтай 41 ББСБ байна.


Зөвхөн финтек зээлийн үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ

Зөвхөн финтек зээл дагнан эрхэлдэг 6 ББСБ-уудын 2023 онд нийт хөрөнгө 139.9 тэрбум төгрөг байна. ББСБ-уудын ашигт ажиллагааг харвал 5 ББСБ нь нийт 45.2 тэрбум төгрөгийн ашигтай, 1 ББСБ 51.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Салбарын хэмжээнд нийт зээлийн үлдэгдлийн 192.5 тэрбум төгрөг буюу 5.2 хувийг эзэлж байна. 2023 онд зөвхөн финтек үйл ажиллагаа эрхэлдэг ББСБ-ууд 1.3 их наяд төгрөгийн зээл олгож, 1.2 их наяд төгрөгийн зээл эргэн төлөгдсөн байна. Энэ нь салбарын нийт олгосон зээлийн 18.7 хувийг, төлөгдсөн зээлийн 20.2 хувийг тус тус эзэлж байна. Олгосон зээл нь зөвхөн иргэдэд олгогдсон бөгөөд богино хугацаатай буюу 12 сар хүртэл байна. Хэрэглэгчдийн тоо 3,168,490 байгаа ба салбарын 69.9 хувь, зээлдэгчдийн тоо 629,488 буюу салбарын 39.3 хувийг эзэлж байна.

Дундаж зээлийн хэмжээ 285.1 мянган төгрөг байна. Зээлийн ангиллаар авч үзвэл санхүүгийн үйлчилгээнд технологийн дэвшил ашиглаж буй эдгээр ББСБ-уудын зээлийн үлдэгдлийн 95.6

хувийг хэвийн, 1.0 хувийг хугацаа хэтэрсэн, 3.4 хувийг чанаргүй зээлийн үлдэгдэл бүрдүүлж байна. Зээлийн жигнэсэн дундаж хүү 4.3 хувьтай байна.

Зураг 7. Финтек зээлийн экосистем



Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

2023 онд иргэн, хуулийн этгээдээс банк бус санхүүгийн байгууллага (ББСБ)-ын үйл ажиллагаатай холбоотой нийт 274 өргөдөл гомдол ирүүлснээс 34.3 хувийг зээлийн мэдээллийн сантай холбоотой өргөдөл, гомдол байна. Зээлийн мэдээллийн сангийн мэдээлэлтэй холбоотой гомдлын хувьд иргэд зээлээ төлөөгүй хугацаа хэтрүүлсэн, өөрсдийн

мэдлэг, мэдээлэл дутмаг байдлаас зээл хойшлуулах хүсэлтээ тухайн ББСБ-д албан ёсоор хүргүүлээгүйн улмаас маргаан үүсэх, улмаар зээлийн мэдээллийн сан дахь зээлийн ангилал буурч бүртгэгдэх тохиолдлууд гарсаар байна. Мөн дээрх байдал нь иргэдийн авсан зээлийн чанар муудахад голлон нөлөөлсөн байна.

VI. МОНГОЛ УЛСЫН ЦАХИМ ЗЭЭЛИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

Хууль эрх зүйн орчин нь хүн төвтэй байх үүднээс 45 ББСБ Финтек үйлчилгээ эрхлэгчдээс байгууллагын нэр бичих шаардлагагүйгээр хариулах судалгаа авсан бөгөөд 27 ББСБ тус судалгаанд хамрагдсан.

Нийт судалгаанд оролцогчдын 33.4 хувь нь 1 жил хүртэлх хугацаанд, 25.9 хувь нь 2 жил хүртэлх хугацаанд, 14.8 хувь нь 3 жил хүртэлх хугацаанд, 14.8 хувь нь 4 жил хүртэлх хугацаанд, 11.1 хувь нь 5 болон 5–с дээш жилийн хугацаанд тус тус үйл ажиллагаа явуулж байна.

Харин нийт судалгаанд оролцогчдын 63 хувь нь одоо хэрэгжиж буй финтекийн хууль эрх зүйн орчныг хангалттай гэж үзэж байгаа бол 37 хувь нь хангалтгүй гэсэн хариулт өгсөн байна. Хангалтгүй гэж үзсэн байгууллагуудын саналаас хууль журамтай холбоотой сайжруулах санал гаргасан байснаас доор дурдав.

- Шүүх, шүүхийн шийдвэрийн үйл ажиллагааг шуурхай болгох;
- Хаягжилтыг шийдвэрлэх (эргээд зээлээ төлөх чадамжгүй болсон зээлдэгчдийн хаяг ихэвчлэн буруу байдаг);
- Зөвшөөрөлтэй финтек байгууллагууд болон Санхүүгийн зохицуулах хороо хамтын ажиллагааг сайжруулах (холбогдох журам, хууль эрх зүйн сайжруулалт);
- Тусгайлан зохицуулсан бие даасан хууль эрх зүйн орчныг бий болгох, зөвшөөрөлтэй финтекүүдээс санал асуулга авч холбогдох журам, бодлогын баримт бичгүүдэд тусгах гэх мэт саналууд ирсэн байна.

Судалгаанд оролцогчдоос Финтек зах зээлийг

хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудлын талаарх саналыг дор дурдав.

- Хэрэглэгчийн бүртгэл үүсгэх явцаас эхлэн холбогдох дугаар, хаяг байршлын мэдээллийн зөрүү, цаашлаад хэрэглэгч санхүүгийн боловсрол дутмаг;
- ISO/IEC 27001 стандартыг нэвтрүүлэхэд зардал өндөр, хугацаа хязгаарлагдмал;
- Финтекийн үйлчилгээ үзүүлэх зөвшөөрөлгүй этгээдүүд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагууд;
- Ногоон бүтээгдэхүүн талаас хууль, эрх зүйн болон эдийн засгийн дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай байгаа;
- Зээлийн мэдээллийн санд мэдээлэл шуурхай мэдээлэл нийлүүлэх.

Энэ асуудлыг хэрхэн хууль, эрх зүйн зохицуулалтаар шийдэж болох вэ? гэсэн асуулгын хүрээнд асуулгад оролцогчид дараах байдлаар хариулжээ:

- Финтек орчны талаар тухайлсан хууль тогтоомж гаргах;
- Цахим зээлийн гэрээ, гарын үсэг нэг талд нь гаргах;
- Хууль эрх зүйн зохицуулалтаас гадуур үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудыг зохицуулалтад оруулж хэрэгжилтийг хангуулах, хэрэглэгчдэд мэдээллийг дэлгэрэнгүй хүргэх;
- Бизнес эрхлэгчдийн дансны хуулга өөрөө зөвшөөрсөн тохиолдолд мэдээллийг нээлттэй болгох;
- Өр орлогын харьцааг өөрчлөх (финтекээс бусад банк бусуудыг оролцуулах).

Судалгааны үр дүн

Судалгаанд оролцогчдын ихэнх нь Финтекийн хууль эрх зүйн орчин хангалттай бүрдсэн байна. Мөн судалгаанд оролцож хангалттай бүрдээгүй гэж үзсэн ББСБ-аас хэрэв үгүй бол хэрхэн сайжруулах хэрэгтэй бэ гэсэн асуултад ихэвчлэн шүүхийн шийдвэрийг шуурхай болгох мөн зээлдэгчийн оршин суугаа хаягжилтыг шийдэх мөн Санхүүгийн зохицуулах хороотой хамтын ажиллагааг сайжруулах саналууд илгээсэн байна.

Финтек зах зээлийг хөгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, хууль, эрх зүйн зохицуулалтаар шийдэж болох саналуудыг харвал хувь судлаачийн зүгээс эдгээр асуудлуудыг шийдэх хэрэгтэй гэж үзэж байна.

1. Зээлдэгчдийн хариуцлагатай зээлийг дэмжих;

2. ISO 27001 стандартыг нэвтрүүлэхэд хэт өндөр зардалтай, хугацаа хязгаарлагдмал байна;
3. Бизнес эрхлэгчдийн дансны хуулга бусад зээл авах хүсэлтэй аж ахуй нэгжүүдийн мэдээллийг нээлттэй болгох;
4. Ногоон бүтээгдэхүүн талаас хууль, эрх зүйн болон эдийн засгийн дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай байгаа;
5. Хууль эрх зүйн зохицуулалтаас гадуур үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудыг зохицуулалтад оруулж хэрэгжилтийг хангуулах;
6. Зээлийн эргэн төлөлтийн ёс зүйн дагуу нөхөн төлүүлж чадаагүй зээлдэгчдийн шүүхийн шийдвэрийг шуурхай болгох;
7. Хаяг бүртгэлийг сайжруулах чиглэлээр улсын бүртгэлтэй хамтран ажиллах.

VII. ДҮГНЭЛТ

Финтек зээлийн үйлчилгээ нь хэрэглэгчдэд санхүүгийн үйлчилгээг илүү хялбар, хурдан хүргэх боломжийг олгодог төдийгүй сүүлийн жилүүдэд интернэт болон гар утасны хэрэглээ нэмэгдсэнтэй холбоотойгоор энэ салбар хурдацтай хөгжиж байна. Технологийн дэвшил нь финтек зээлийг илүү хүртээмжтэй болгож, дэлхий даяар өргөжиж байгаа нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлж, хэрэглэгчдэд шинэ боломжуудыг бий болгосон.

Ковид-19 цар тахлын үеэс хойш финтек зээлийн зах зээл хурдацтай тэлж байгаа бөгөөд дэлхийн олон улс орнууд энэ зах зээлийн өсөлтөд зориулсан зохицуулалтын орчныг сайжруулах шаардлагатай тулгарч байна. Улс

орон бүр өөрийн онцлог, зах зээлийн нөхцөл байдлыг харгалзан зохицуулалтын тусгай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа бөгөөд энэ нь хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдал, мэдээллийн аюулгүй байдал зэрэг сорилтуудыг даван туулахад чиглэгдэж байна.

Тухайлбал, Танзани Улсад финтек зээлийн зохицуулалт нь санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгаа ч мэдээлэл, чадавхын хувьд цаашид сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. Харин өндөр хөгжсөн Их Британи Улсад зохицуулалтын орчин бүрдсэн бөгөөд Финтекийн зээлийн салбарт ил тод байдал,

хэрэглэгчийн хамгаалалтад ихээхэн анхаарал хандуулдаг. Энэтхэг Улсын хувьд финтек зээлийн хурдацтай өсөлт нь хэрэглэгчийг хэт өрөнд оруулах, мэдээллийн нууцлалыг зөрчих зэрэг эрсдэлүүдийг зохицуулах шинэ журам, аргачлалыг авч хэрэгжүүлсэн.

Монгол Улсын хувьд финтек зээлийн зохицуулалтын орчныг улам бүр сайжруулах хэрэгцээтэй байна. Эдгээр улс орнуудын туршлагаас суралцаж, хэрэглэгчийн

эрхийг хамгаалах, зээлийн мэдээллийн санг сайжруулах, ил тод байдлыг хангах, зохицуулагч байгууллагын чадавхыг нэмэгдүүлэхэд анхаарах шаардлагатай. Монгол Улсад финтек зээлийн өсөлтөөс үүдэн гарах эрсдэлүүдийг хянах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд зохицуулалтын орчныг илүү боловсронгуй болгож, инновацыг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх нь нэн тэргүүний зорилт болно.

САНАЛ

- Их Британи Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар сайн туршлагыг нэвтрүүлэх.
- Санхүүгийн боловсролыг дэмжих арга хэмжээг олон улсын зохицуулагч байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх
- Мэдээллийн нууцлал ба кибер аюулгүй байдлын нарийвчилсан судалгаа хийх
- Зээлдэгчдийн хариуцлагатай зээлийг дэмжих мэдээллийн аюулгүй байдлын сайжруулах зорилгоор төр хувийн хэвшлүүдтэй хамтарсан аян өрнүүлэх.
- BUY now, Pay later үйлчилгээг цахим зээлийн нэг төрөл учир өр орлогын харьцаатай уяж зээлийн мэдээллийн сантай холбох. Мөн мэдээллийн аюулгүй байдлын ISO 27001 стандарт мөрдүүлэх шаардлагатай.
- Жигнэсэн дундаж хүү хэт өндөр байгууллагуудын шалтгааныг тодруулж, бодлогын арга хэмжээ авах;
- Ногоон бүтээгдэхүүн талаас хууль, эрх зүйн болон эдийн засгийн дэмжлэгийг үзүүлэх шаардлагатай байна.
- Хууль эрх зүйн зохицуулалтаас гадуур үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагуудыг зохицуулалтад оруулж хэрэгжилтийг хангуулах.
- Жижиг дунд бизнес эрхлэгчдэд финтек зээлийн үйлчилгээг онлайнаар авах боломжийг бүрдүүлэх.

VIII. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Reserve Bank of India. “Guidelines on Digital Lending.” 2022. Available at: <https://rbi.org.in/Scripts/NotificationUser.aspx?Id=12382&Mode=0>
- Reserve Bank of India. “Digital Lending Guidelines.” 2022. Available at: <https://www.rbi.org.in/commonperson/English/Scripts/FAQs.aspx?Id=3413>
- Reserve Bank of India. “THE CREDIT INFORMATION COMPANIES (REGULATION) ACT, 2005.” 2005. Available at: <https://www.indiacode.nic.in/bitstream/123456789/2057/2/A200530.pdf>
- Reserve Bank of India. “Master Circular – Fair Practices Code.” 2011. Available at: <https://www.rbi.org.in/commonperson/English/Scripts/Notification.aspx?Id=867>
- PRS India. “The Digital Personal Data Protection Bill.” 2023. Available at: <https://prsindia.org/billtrack/digital-personal-data-protection-bill-2023>
- Reserve Bank of India. “Business Continuity Planning.” 2022. Available at: <https://rbi.org.in/scripts/PublicationReportDetails.aspx?UrlPage=&ID=622>
- Ministry of Electronics & Information Technology. “National Cyber Security Policy.” 2013. Available at: https://www.meity.gov.in/writereaddata/files/National_cyber_security_policy-2013_0.pdf
- Reserve Bank of India. “Draft Enabling Framework for Regulatory Sandbox.” 2019. Available at: <https://rbi.org.in/scripts/PublicationReportDetails.aspx?UrlPage=&ID=920>
- Bank of Tanzania. “The Bank of Tanzania Act.” 2006. Available at: <https://www.bot.go.tz/BOTAct2006.pdf>
- Bank of Tanzania. “Microfinance Act.” 2018. Available at: <https://tanzlii.org/akn/tz/act/2018/10/eng@2018-11-23>
- “Evolution of Digital Lending in Fintech: India – UK Comparison.” 2023. Available at: https://papers.ssrn.com/sol3/Delivery.cfm/SSRN_ID4558960_code5910975.pdf?abstractid=4558960&mirid=1&type=2
- Tanzania. “The electronic and postal communications act.” 2018. Available at: [https://www.tcra.go.tz/uploads/documents/sw-1619087013_The%20Electronic%20and%20Postal%20Communications%20\(Consumer%20Protection\)%20Regulations,%202018.pdf](https://www.tcra.go.tz/uploads/documents/sw-1619087013_The%20Electronic%20and%20Postal%20Communications%20(Consumer%20Protection)%20Regulations,%202018.pdf)
- UNCDF. “Financial Inclusion Framework.” 2023. Available at: <https://policyaccelerator.uncdf.org/whats-new/tanzania-new-national-financial-inclusion-framework#:~:text=The%20NFIF%20sets%20out%20specific,their%20participation%20in%20economic%20activities.>
- Bank of Tanzania. “Consumer Protection.” 2023. Available at: <https://www.bot.go.tz/DFDI/ConsumerProtection>

- Bank of England. “New firm authorisation – supporting documents required for credit union applications.” 2024. Available at:
<https://www.bankofengland.co.uk/-/media/boe/files/prudential-regulation/authorisations/new-firm-authorisation/new-firm-authorisation-supporting-documents-for-credit-union-applications.pdf>
- United Kingdom, “Financial Services and Markets Act.” 2000. Available at:
<https://www.legislation.gov.uk/ukpga/2000/8/contents>
- Financial Conduct Authority. “Supporting material for applications by consumer credit, mortgage and other consumer finance firms” 2023. Available at:
<https://www.fca.org.uk/firms/authorisation/supporting-material-credit-mortgage-consumer-finance>
- United Kingdom. “Data Protection Act.” 2018. Available at:
<https://www.legislation.gov.uk/ukpga/2018/12/contents>
- EU. “General Data Protection Regulation.” 2018. Available at:
<https://gdpr-info.eu/>
- United Kingdom. “Financial Ombudsman Service.” 2024. Available at:
<https://www.financial-ombudsman.org.uk/#:~:text=The%20Financial%20Ombudsman%20Service%20is,power%20to%20put%20things%20right.>
- Cambridge Centre for Alternative Finance. “The Future of Global Fintech: Towards Resilient and Inclusive Growth.” 2024. Available at:
[https://www.jbs.cam.ac.uk/faculty-research/centres/alternative-finance/publications/the-future-of-global-fintech-towards-resilient-and-inclusive-growth/#:~:text=Looking%20ahead%2C%20artificial%20intelligence%20\(AI,development%20in%20the%20near%20future.](https://www.jbs.cam.ac.uk/faculty-research/centres/alternative-finance/publications/the-future-of-global-fintech-towards-resilient-and-inclusive-growth/#:~:text=Looking%20ahead%2C%20artificial%20intelligence%20(AI,development%20in%20the%20near%20future.)
- University of Cambridge. “The Global Covid-19 Fintech Market Rapid Assessment Study.” 2020. Available at:
<https://www.jbs.cam.ac.uk/wp-content/uploads/2020/12/2020-ccaf-global-covid-fintech-market-rapid-assessment-study.pdf>
- Technidentity. “Leadership insight: From Cyberspace to your pocket – Evolution of Digital Lending.” 2023. Available at:
<https://www.technidentity.com/insights/leadership-insight-from-cyberspace-to-your-pocket-evolution-of-digital-lending/>
- AFI. “Policy Framework for Responsible Digital Credit.” 2020. Available at:
<https://www.afi-global.org/publications/policy-framework-for-responsible-digital-credit/>
- AFI. “Digital Credit Regulation in Tanzania.” 2020. Available at:
<https://www.afi-global.org/publications/digital-credit-regulation-in-tanzania/>
- BIS. “FinTech credit: Market structure, business models and financial stability implications” 2017. Available at:
https://www.bis.org/publ/cgfs_fsb1.htm

- Australian Securities & Investments Commission. “Marketplace lending (peer-to-peer lending) products.” 2020. Available at:
<https://asic.gov.au/regulatory-resources/financial-services/marketplace-lending/marketplace-lending-peer-to-peer-lending-products/#what-is>
- Lexology. “First-step analysis: fintech regulation in Germany.” 2023. Available at:
<https://www.lexology.com/library/detail.aspx?g=d6203c94-3a00-49a9-9273-0aeab22af711#:~:text=The%20German%20Federal%20Financial%20Regulatory,of%20regulated%20activities%20or%20products.>
- HM Treasury. “Regulation of Buy-Now PayLater.” 2023. Available at:
https://assets.publishing.service.gov.uk/media/63ea41a9e90e077bbb30a4fc/BNPL_consultation_on_draft_legislation.pdf
- Санхүүгийн зохицуулах хороо. “ББСБ-аас олгох финтек зээлийн бүтээгдэхүүнд өр, орлогын харьцаа тогтоох тухай” 2022. Эх үүсвэр:
http://www.frc.mn/resource/frc/Document/2022/10/14/d9euerxqn23vq0tf/20221014_527.pdf
- Санхүүгийн зохицуулах хороо. “Банк бус санхүүгийн зээлийн үйл ажиллагааны журам” 2022. Эх үүсвэр:
http://www.frc.mn/resource/frc/Document/2023/02/20/hknmrv4lquo19mpa/frc_160-2023%20%D0%BD%D1%8D%D0%BC%D1%8D%D0%BB%D1%82%20%D3%A9%D3%A9%D1%80%D1%87%D0%BB%D3%A9%D0%BB%D1%82%D1%82%D1%8D%D0%B9.pdf
- Санхүүгийн зохицуулах хороо. “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” 2020. Эх үүсвэр:
<http://www.frc.mn/resource/frc/Document/2021/11/19/u92m056pixh8qsvf/998.pdf>
- Монгол улс. “Зээлийн мэдээллийн тухай.” 2011. Эх үүсвэр:
<https://legalinfo.mn/mn/detail/9175>
- Санхүүгийн зохицуулах хороо. “Бүртгэлтэй финтек аппликэйшн.” 2024. Эх үүсвэр:
<http://frc.mn/#/sct;id=12/doc/decree/998>
- Санхүүгийн зохицуулах хороо. “Санхүүгийн салбарын тойм 2023 он.” Эх үүсвэр:
<http://frc.mn/resources/Images/Document/202403/n5zrJ/Urult-toim-2024.03.11.pdf>